

Jonh E. Fryman, Ph.D.

THE BIBLE...BASICALLY MINISTRIES INTL INC.

Ft. Worth, Texas

הַמִּשְׁכָּן
...
וְהָאֵלֹהִים
עִמָּם

СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

*Он тооллын хураангуй
(Сургалтын туслах материал тусдаа)*

“БИБЛИ ... ҮНДСЭНДЭЭ” сургалт

Библийн хувьд бичиг үсэггүй мэт байдлыг арилгах дагалдагчийн сургалт

СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

Эхний хэсэг: “Он тооллын хураангуй”

Хоёрдугаар хэсэг: Сургалтын туслах материал

John E. Fryman, Ph.D.

Төслийн үндэслэгч, хөгжүүлэгч

The Bible...Basically Ministries International Inc.

Fort Worth, Texas

www.biblebasically.com

Монгол хэлэнд ном болон слайдыг хөрвүүлэхэд ажилласан баг (2004-2010):

Dr. Rick Griffith (төслийн ерөнхий удирдагч)

Ж. Бадамдорж (Монгол хэлэнд хөрвүүлэх ажлын ерөнхий зохицуулагч)

Enke (багшийн материалын орчуулагч)

Г. Түмэнбаяр (слайдын орчуулагч)

Д. Батбаяр (слайдын орчуулагч)

Л. Амаргүвшин (слайдын орчуулагч)

З. Уянга (слайдын орчуулагч)

Сургалтын материалын эхний хэсгийн (Он тооллын хураангуй) эх бэлтгэлийг
“Мараната Паблишн” ХХК хийв.

АГУУЛГА

Өмнөх үг ...	4
Энэхүү номын талаар хэдэн үг ...	6
Он тооллын хураангуй ...	8

1-р хэсэг:

“Библийн файл” нээцгээе ...	10
-----------------------------	----

2-р хэсэг:

Тайзаа засъя: Эртний ойрхи дорнодын газрын газрын зургийг зурцгаая ...	17
---	----

3-р хэсэг:

Файлын задаргаа ...	21
БҮТЭЭЛ ...	21
АБРАХАМ ...	23
ИОСЕФ ...	29

Эхний тойм ...	31
МОСЕ ...	32
ИОШУА ...	35
АНАРХИ ...	37
ХААНЧЛАЛ ...	38

Хоёр дах тойм (Завсарлага)...	44
КОЛОНЧЛОЛ ...	47
ЧИМЭЭГҮЙ ҮЕ ...	48
ЕСҮС ...	49

4-р хэсэг

Библийн түүхийг товчоор ...	52
Эцэгт нь дүгнэхэд ...	57
Библийн файл ...	59

ӨМНӨХ ҮГ ...

Христитгэл нь хувь хүний итгэл дээр, мөн багтай баримт дээр тогтдог. Бидний итгэл бишрэлийн үнэн баримтыг мэдэхгүй байх нь хэзээ ч цөмөрч болох нимгэн мөсөн дээр алхаж буйтай адил юм.

Бидний итгэл бишрэлийн баримтыг цэгцтэйгээр тэмдэглэн бичсэн ном бол Библи буюу Бурханы Үг юм. Библи нь аль ч цаг үеийн хүний амьдралд үнэ цэнээ өгч чадах эрх мэдэлтэй, хувь хүн ойлгож болохуйц, түүхэн цаг үетэйгээ нягт уялддаг Ариун Бичээс (Судар) юм.

Ихэнх хүн Бурханы Үгийг “ойр дотно” мэддэггүйг олон цагийн судалгаа, хувийн туршлагаасаа мэдэрсэн юм. Олонх итгэгчид Библид өгүүлж буй гол хүн, түүхийг мэддэг нь үнэн. Харин тэдгээр нь хэрхэн холбогдож нэгэн утгыг гаргаж буйг хувь хүний хэрээр хэтэрсэн асуудал гэж боддог нь нууцгүй зүйл юм.

Тиймдээ ч, олон итгэгчид Библийг хааяахан нэг уншдаг бололтой. Тэд хувийнхаа амьдралд Библийг хэрхэн хэрэгжүүлэхээсээ өмнө тайлбарыг нь бусдад үлдээдэг. Тухайлбал, пастор, багш нар, христитгэлт зохиолч нар, радиогийн болон телевизийн хөтлөгч нарт даатгадаг байдал харагдаж байна.

Библи олонх хүний хувьд хаалттай ном болон хувирчээ. Библийн талаарх мэдлэг, итгэлийг босгон байгуулах гайхамшигт түүхүүд нь ямар нэг байдлаар эмх цэгцгүй байдлаар тархинд нь суусан байдалтай байна. Тиймээс л, итгэгч болон итгэгч бус хүний аль алинд нь Библийн агуу үнэн,

Эхлэлээс Илчлэлт хүртэл нягт нэхэгдсэн нэхээс шиг уялдаатай гэдгийг харуулахыг би зорилоо.

Хүн төрөлхтөнийг аврах төлөвлөгөө Бурханд байсан ба энэ нь тэртээ холын Манай Эзэний Өмнөх 2000 гаруй жилийн тэртээ амьдарч байсан Абрахаамаас эхэлнэ. Бидний Аврагч эртний Израилиас авахуулаад өөрийн биеэр ирэх хүртэл үйл явдал хэрхэн өрнөж буйг бид дахин нэг харах цаг болжээ.

Энэхүү сургалт Бурханы Үгийг оюун бодолд тань цэгцтэй болгож цаашид гүнзгийрүүлэн судлахад тань Бурханы Үг та хоёрыг холбоосой гэж бид таны төлөө залбирнам. Энэ сургалтын материалыг уншигч таны дотор Өөрийнхөө Үгэн дотроо Өөрийгөө илчлэх Бурхан Аавын алдар, Түүний Хүү Есүсийн сайн мэдээ улам тод томруун болох болтугай гэж таны төлөө чин сэтгэлээсээ залбирч байна.



Доктор Жон Е. Фрайман

ЭНЭХҮҮ НОМЫН ТАЛААР ХЭДЭН ҮГ

Ямар ч материалын дизайны гол санаа нь хэрэглэхэд тэр нь хялбар, ойлгомжтой, үр өгөөжтэй байхад байдаг билээ. Энэ зарчмыг мөрдлөг болгон *Он Тооллын Хураангуй* гэсэн хэсгийг өөрөө сурах бичиг хэлбэрээр зориуд бэлтгэсэн юм. Үзүүлэнтэйгээр, дахин давтах хэлбэрээр өөрөө сурах хэлбэрээр сурах нь илүү үр дүнтэйг бид цаг хугацааны турш харсан. Энэхүү сургалтын үндсэн ганц зорилго нь: Библийн талаарх эмх цэгц, дэс дараалалгүй байгаа баримт, түүх, чухал хүмүүсийн амьдрал болон Библийн гол санааг итгэгч бүрт ойлгомжтой цэгцэлж өгөхөд оршиж байгаа юм.

Хэрэв та энэхүү “Онтооллын хураангуйг” анхааралтайгаар бусад үзүүлэнгийн материалтай хамт гурваас зургаан цаг унших юм бол энэ зорилго биелэх боломжтой.

Материалын ерөнхий зохион байгуулалтыг танилцуулъя. Сургалтын материал өөрөө танд багшлах юм. Хичээлийн агуулгыг бичсэн үндсэн баганаас гадна, хуудасны захад буй нарийн баганыг та анзаарсан байх. Тэрхүү нарийн баганын дээр **“Өрнөх цэг”** гэж бичсэн буй. Тэнд хичээлийн агуулгатай холбоотой үзүүлэн зураг, Библийн ишлэл, хичээлийн тэмдэглэл зэрэг материалаа өөрийн болгоход тань туслах зорилготой зүйлсийг багтаасан байгаа шүү.

Багш голлох санаагаа тод томруун болгохын тулд тухайн үг болон өгүүлбэрийг **тод хараар**, *ташуугаар*, эсвэл БҮГДИЙГ НЬ ТОМ ҮСГЭЭР бичсэн байгаа.

Энэхүү сургалтын материалын **-р хуудсанд** “Библи... Үндсэндээ” сургалтыг багш заах үед гэсэн ойлголт ямархуу болж харагдахыг харуулсан байгаа.

Сургалтын “систем”-ийг өөрийн болгох талаар хэдэн үг хэлье. Та аль болох хурдан хугацаанд ой тойндоо энэ ойлголтыг өөрийн болгоно төдий хэмжээгээр та бусдад илүү үр дүнтэйгээр сурсан зүйлээ хүргэж чадна.

“Өрнөх цэг” баганад буй материал нь “Он тооны хураангуйтай” хамтатган уншихад **“Библийн Файл”** гэсэн ойлголтыг танд улам тодорхой болгох зорилготой гэдгийг санаж байна биз ээ.

Нэмэлт зүйл гэвэл сургалтын хоёрдугаар хэсэгт “БИБЛИ...ҮНДСЭНДЭЭ”[®] сургалтын явцад суралцагсад бичиж тэмдэглэх материалыг бий бөгөөд энэ нь тусдаа материал байгаа. Тэнд буй ихэнх материал нь “Он тооны хураангуй” хэсэгт хэрэглэсэн байгаа болно.

Эцэст нь хэлэхэд “БИБЛИ...ҮНДСЭНДЭЭ”[®] материалыг өөрийн болгоход та хувь хүнийхээ хувьд итгэлээр төлөвшихөөс гадна бусдад сайн мэдээг тунхаглах таатай боломжийг гаргах юм. Бурханы Үгэнд хандах таны хандлага маш хүчтэй хувирч өөрчлөнө хэмээн би амлах байна.

*Библийг “Том зургаар нь”
харна гэдэг нь маш чухал
үндсэн ойлголт юм.*

Библийн “Том зураг”-ийг харах нь

Доктор Хенриетта Меарс бол XX зууны Библийн агуу багш нарын нэг юм. Др. Меарс өөрийн номдоо “Хүмүүсийн, Библийн мэдлэг Сувдан зүүлтний хэлхээ мэт байх ёстой атал... ихэнх Библи уншигчдын бодол хэлхээ нь тасарсан зүүлт шиг Библийн түүхүүд нь эмх цэгцгүй, ард урдаа орж төөрөлдсөн байдалтай байдаг” гэж бичжээ. Зүүлт хэрэв тасарсан бол зүүлтний сайхныг хэрхэн мэдэх билээ.

Бүтээгч бидний уураг тархийг аливааг цэгцтэй ойлгож байхаар бүтээжээ. Компьютерт байдаг файлын системтэй төстэй байдлаар бидний тархи аливааг ялгаж ангилдаг. Гэр бүлд хамаатай хэсэг, ажил төрөлд хамаатай хэсэг, санхүүтэй хамаатай хэсэг, сүнслэг зүйлстэй хамаатай гэх мэтчилэн ангилна. Ингэж л бид аливааг *зохион байгуулалттайгаар* боддог, хийдэг. Зарим хүн зохион байгуулах тал дээрээ бусдаасаа илүү байдаг. Ийнхүү сайн зохион байгуулалттай байхыг тэдгээр хүмүүс олон жилийн өмнө сурч үүнийгээ урт хугацааны турш хэрэглэж заншсан хүмүүс байдаг.

Ой ухаандаа “Библийн Файл”-аа байгуулсан уу?

Оюун ухаандаа Библийн цэгцтэй ойлголттой болохын тулд “Библийн Файл” гэх зүйлийг ой ухаандаа байгуулах хэрэгтэй болно. Эзэн Есүсийг бодох бүр, Түүний бичүүлсэн Ариун Бичээсийг унших бүр энэ файлаа нээх хэрэгтэй. Бурханы Үгийг уншихдаа, номлол сонсохдоо, сүнслэг зүйлийн талаар бодож мөн ярихдаа энэ файлаа та нээнэ. Сүнслэг төлөвшилд хүрэхэд “Библийн файл” танд зайлшгүй хэрэгтэй болно.

Олон хүний хувьд **“Библийн Файл”** нь тийм ч сайн зохион байгуулттай байдаггүй. Библийн янз бүрийн түүх, баримт, газрын зураг, хүмүүсийн нэрс, он тоолол бүгд эмх цэгцгүй байдалтай байдаг.

“Гэхдээ” гэж ирээд та “Бурханы Үгийг заавал дэс дараалалтай нь тогтоох тийм чухал юм уу?” асуух байх. Би “Тийм” гэж хариулна. Энэ талаар

*Бидний ой ухаанд
“Библийн Файл” байх
хэрэгтэй юм.*

тохирох нэгэн жишээ өгье л дээ:

Цагаан сарын золголт

Сар шинээр золгох гэсэн чинь та гэнэт ой санамжаа алдчихаж гэнэ. Тэгээд танай гэрт байгаа хамаатнуудын хэн нь хэний хүүхэд, хэн нь хэнтэйгээ холбогдож байгааг та мэдэхээ байчихаж. Гэр бүлийн “дотно” холбоос мэдрэгдэхээ больж. Мэдээж та инээж хөхрөөд дунд нь сууж болох ч тэнд байгаа хүмүүстэй харилцах харилцаа чинь ямар утга учиртайг та төсөөлөх ч үгүй.

Бурханы Үгтэй харилцах харилцаа ч үүнтэй адилхан. Олон итгэгчид Библид өгүүлдэг түүх, баримт, хүмүүсийн нэр, газар усны нэр, он тооллыг хольж хутгадаг. Библийг уншиж байхдаа хүртэл энэ нь бусад хэсэгтэйгээ ямар чухал холбоотой болохыг ойлгодоггүй өнгөрөх явдал гаргадаг.

Гэхдээ ийм байдалтай удаан явж болохгүй ээ. Библид өгүүлсэн бүх түүх, баримт, мэдээллийг хооронд нь утга учиртайгаар ой ухаандаа маш амархан, мөн хурдан ойлгоход багахан хэмжээний судалгаа хийхэд л энэ бүхний учир олдоно.

“Библийн Файл”-аа цэгцлэх цаг болжээ!

Ой ухаандаа “Библийн Файл”-аа маш хурдан цэгцлэх системд та суралцах болно. Ямар ч зүйлийг цэгцтэй болгохын тулд систем хэрэг болдог. Библийн гол үйл явдлууд хоорондоо хэрхэн холбогдож байгааг мэдэхэд энэ систем танд тусална.

Он тооллын хураангуй нь бидний эзэмших хэрэгтэй системтэй ойлголтыг өгнө. Библийн өгүүлж буй гол түүх хэрхэн олон үйл явдалтай уялдаж байгааг маш богино хугацаанд, хэсэг судалгаа, ажиглалт хийсний эцэст та түвэггүй ойлгох болно. Сургалтын дараа ердөө 20 минутын дотор Бурханы Үгийг хэрэглэн бусдад Библийн тухай гэрчлэх чадвартай болох болно.

Та биш, би гэж үү? Зүгээр л туршаад үз. Ямар амархан энэ бүхэн болдгийг системтэйгээр танилцуулсан, хуудас бүрт өгүүлж буй мэдээллийг уншаарай.

За эхлэхэд бэлэн үү? Хамтдаа хийцгээе!

Өрнөх цэг

Баримтуудыг хооронд нь холбож ойлгох нь бидэнд Библийн талаар гүн ойлголттой болоход тусалдаг.

Энэ хэсгээс эхлэн “Өрнөх цэг” танд Библийн Файлыг хэрхэн өөрийн болгох вэ гэсэн асуултад хариулж туслах болно. Өөртөө тэмдэглэл болгон, бусдад заах үедээ ашиглаарай.

Өрнөх цэг

Библийг “Он тооллоор нь” сурах маш чухал.



**АНХААР!
ТУСЛАХ ГАРЫН
АВЛАГЫН 1 БОЛОН
2-Р ХУУДСЫГ
ХЭРЭГЛЭЖ ЭНЭ
ХЭСГИЙГ ӨӨРИЙН
БОЛГОЖ АВНА УУ.**

Эхлэх томъёо нь:
Б 7 Ч Е

Тэр 7-ийн тоо нь
хуваагдаад:

$$7 = 4 + 3$$

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: “БИБЛИЙН ФАЙЛ” НЭЭЦГЭЭ

Библийг ой тойндoo ортол тогтоох хамгийн шилдэг арга нь “кроник” хэлбэр буюу “он тооллын хураангуй” хэлбэрээр тогтоох арга юм. Хуучин болно Шинэ Гэрээг хооронд холбож байгаа системчилсэн үйл явдлууд бий. Энэ холбоосыг бид ийнхүү нэрлэлээ:

ОН ТООЛЛЫН ХУРААНГУЙ

Юуны өмнө файл хадгалдаг шүүгээг дотроо төсөөлье. Танд Библийг бүхэлд нь **ой ухаандаа багтаах 10 ширхэг Библийн файл** хэрэгтэй. Тэдгээрийн дараалал нь маш чухал бөгөөд түүнийг хольж сольж болохгүй.

1-р алхам

Бид *гурван үсэг, нэг тоотой* томъёогоор эхэлье.

Б 7 Ч Е

Библийн үндсэн ойлголтыг багцалсан дээрх томъёог дотроо хэд хэдэн удаа чангаар хэлж цээжлээрэй.

“Б 7 Ч Е ... Б 7 Ч Е ... Б 7 Ч Е ... гм”

2-р алхам

Долоогийн тоо нь “7” дундуураа зураастай байгааг та анзаарав уу? Тэр зураасанд их учир бий шүү. Тэрхүү зураас “-” нь 7-ийн тоог хоёр хэсэгт хувааж байгаа юм. 7-г хоёрт хуваавал ямар тоо гарах вэ гэж та бодож амжсан байх. Хариулт нь:

4 ба 3

Тэгээд **Б 7 Ч Е** байснаа, 7 нь 4 болон 3 гэж хуваагдвал томъёо маань ингэж задарч байна:

Б 4 3 Ч Е

Өмнө нь хэлсэнчлэн, дээрх томъёог дотроо хэд хэдэн удаа чанга хэлж тогтоож аваарай.

3-р алхам

Одоо **Б 4 3 Ч Е** дээрээ тулгуурлан, **таван чухал үгийг харья**. Тэдгээр таван үгс нь бидний оюун ухаандаа бүтээх **Библийн Файлын** суурь болно. Тэдгээр нь:

Б = БҮТЭЭЛ
4 = 4 ХҮН
3 = 3 НИЙГЭМ
Ч = ЧИМЭЭГҮЙ ҮЕ
Е = ЕСҮС

Дээрх 5 үг нь Библийн бүтнээр нь өгүүлж чадах гол томъёо юм. *Одоо энэхүү таван үгийг задалж дэлгэрүүлье.*

4-р алхам

БҮТЭЭЛ

Мэдээж энэ нь жагсаалтын эхэнд орох ёстой. Дараагийн тоо нь тэгвэл:

4 ХҮН

Хэн хэн багтаж байгааг дарааллаар нь тодорхой хэлбэл:

АБРАХАМ
ИОСЕФ
МОСЕ
ИОШУА

Өрнөх цэг

Эхлээд ийм байсан:

Б 7 Ч Е

Дараа нь:

7 = 4 + 3

Одоо задраад:

БҮТЭЭЛ
4 ХҮН
3 НИЙГЭМ
ЧИМЭЭГҮЙ ҮЕ
ЕСҮС

Энд байгаагаа задалвал:

БҮТЭЭЛ
4 ХҮН
3 НИЙГЭМ
ЧИМЭЭГҮЙ ҮЕ
ЕСҮС

4 хүн гэдэгт:

Абрахам
Иосеф
Моце
Иошуа

Өрнөх цэг

Үүнийг мөн хөгжилтэй
байдлаар тогтоож болно.

“Агуу Итгэлийг Мөнхлөгч Ирнэ”

Одоо жагсаалт маань:

**БҮТЭЭЛ
АБРАХАМ
ИОСЕФ
МОСЕ
ИОШУА**

Дахин сануулахад:

**БҮТЭЭЛ
4 ХҮН
3 НИЙГЭМ
ЧИМЭЭГҮЙ ҮЕ
ЕСҮС**

Үгийн эхний үсгийг хэд хэдэн удаа чангаар дуудаж хэлэх нь цээжлэхэд их ашиг тустай.

“А-И-М-И ... А-И-М-И ... гэх мэт”

Дөрвөн хүний нэрийг дотроо хоногштол хэлж цээжлээрэй.

“АБРАХАМ, ИОСЕФ, МОСЕ, ИОШУА”

Жагсаалтаа эхнээс нь жагсаавал:

	БҮТЭЭЛ
	АБРАХАМ
4 ХҮН	ИОСЕФ
	МОСЕ
	ИОШУА

Библийн Файлын 4 ХҮН гэсэн хэсгийг ийнхүү ерөнхийд нь үзэж дууслаа. Мэдээж Библид олон чухал хүн гардаг ч **Библийн Файлд** энэ 4 хүний нэр зайлшгүй орох шаардлагатай юм. Дээрх 4 хүний нэрийг дотроо хоногштол тогтоогоорой.

5-р алхам

Дараагийн үндсэн гурав дахь хэсэг рүү орцгооё.

3 НИЙГЭМ

Энд дараах 3 нийгэм багтаж байна.

**АНАРХИ
ХААНЧЛАЛ
КОЛОНЧЛОЛ**

Өмнө хэлсэнчлэн, дээрх гурван үгийг тогтоогоорой.

Одоо үндсэн жагсаалт дээр **3 НИЙГЭМ** нэмэгдвэл:

**БҮТЭЭЛ
АБРАХАМ
ИОСЕФ
МОСЕ
ИОШУА
АНАРХИ
ХААНЧЛАЛ
КОЛОНЧЛОЛ**

Өмнө хэлсэнчлэн, дээрх гурван үгийг тогтоогоорой.

Энэ хүртэл сурснаа эргэн дүгнэе.

Б 7 Ч Е

дараа нь,

Б 4 3 Ч Е

Дээрх үсэг, тоонууд Библийн гол тоймыг өгүүлэх **АРВАН ҮГИЙГ** бий болгож байгаа юм.

Б 4 3 Ч Е нь дараах байдлаар дэлгэрэнгүй болно.

**БҮТЭЭЛ
4 ХҮН
3 НИЙГЭМ
ЧИМЭЭГҮЙ ҮЕ
ЕСҮС**

Үүнээсээ илүү задраад ийм болж байгаа.

**БҮТЭЭЛ
АБРАХАМ
ИОСЕФ
МОСЕ
ИОШУА
АНАРХИ
ХААНЧЛАЛ
КОЛОНЧЛОЛ**

Өрнөх цэг

3 нийгэм гэдэгт:
**АНАРХИ
ХААНЧЛАЛ
КОЛОНЧЛОЛ**

ТОЙМ

Дахин сануулахад:
Б 7 Ч Е

*Задраад ийм болж
байгаа:*
Б 4 3 Ч Е

Дээрх товчлол задраад:
**БҮТЭЭЛ
4 ХҮН
3 НИЙГЭМ
ЧИМЭЭГҮЙ ҮЕ
ЕСҮС**

Өрнөх цэг

Эцэст нь
жагсаалт маань бүрэн
боллоо!

**БҮТЭЭЛ
АБРАХАМ
ИОСЕФ
МОСЕ
ИОШУА
АНАРХИ
ХААНЧЛАЛ
КОЛОНЧЛОЛ
ЧИМЭЭГҮЙ ҮЕ
ЕСҮС**

Энэхүү “Библийн
Файл”-ын 10 гол үгийг
ой тойндоо баттай
тогтоож аваарай.

6-р алхам

Эцэст нь бид жагсаалтынхаа сүүлч хэсэгт,

ЧИМЭЭГҮЙ ҮЕ

МӨН

ЕСҮС

гэж нэмээд үндсэн Библийн Файлын 10 файлыг
дуусгаж байгаа юм.

6-р алхам

Библийн Файлын бүтэн жагсаалтыг
бичвэл ийм болж байна.

Б 7 Ч Е


нь задраад ийм болсон

**БҮТЭЭЛ
4 ХҮН
3 НИЙГЭМ
ЧИМЭЭГҮЙ ҮЕ
ЕСҮС**

... тэгээд эдгээрийг бүгдийг нь дэлгэрүүлбэл
Библийн Файлын үндсэн 10 гол үгийг гаргаж
ирж байгаа юм.

**БҮТЭЭЛ
АБРАХАМ
ИОСЕФ
МОСЕ
ИОШУА
АНАРХИ
ХААНЧЛАЛ
КОЛОНЧЛОЛ
ЧИМЭЭГҮЙ ҮЕ
ЕСҮС**

За одоо, энэхүү **10 гол үгийг Библийн файлынхаа хавтас дээр гарчиглаж толгойдоо хийх цаг боллоо!** Таны ой ухаанд байх ёстой Библийн Файл нэг иймэрхүү харагдах юм.



Тодорхой, дэс дараалалтай, санаж хэрэглэхэд амар хялбар бүтэцтэй таны оюун ухаанд бий болсон Библийн Файл нэг иймэрхүү харагдана.

Оюун ухаандаа бий болгосон таны **Библийн Файл** танд маш их хэрэг болно гэдгийг санаарай. Эдгээрийн дэс дарааллыг урд хойно нь оруулж болохгүй тул яг дэс дарааллаар нь цээжилнэ үү. Энэхүү Библийн Файл (бичиг хэргээ хадгалдаг “Хавтас” гэж ойлгож болно) дотор Библийн бүхий л гол үйл явдал бичигдэх болно. Цэгцтэй байдлаар ингэж тогтоох нь насан туршид тань таны амьдралд ач холбогдлоо өгөх болно.

Библийн Файлаа гарчигласны дараа яах вэ?

Оюун ухаандаа “Библийн Файл” хэмээх системийг бий болгож байгаагаа та санаж байгаа байх. Энэ систем нь Библийг нарийвчилж бус харин үндсэн гол санааг ойлгоход туслах зорилготой юм. Тийм ч учраас энэ сургалтыг “Библи ... Үндсэндээ” буюу “Библи Үндсэндээ юуны тухай өгүүлдэг тухай заах зорилготой” сургалт юм.

Гарчигласан Библийн файлын дагуу бид Библийн **үндсэн он тооллын хураангуйг**, болж өрнөсөн **түүхийн хамт** үзэх юм. Ийнхүү үзэхдээ: *Библийн гол гол үйл явдлуудыг, Библийн*

Өрнөх цэг

ХЭРЭГЖҮҮЛЭЛТ!
Библийн Файлынхаа “хавтсыг” гарчиглах цаг боллоо! 10 ширхэг тусдаа хавтас бүр тусдаа нэртэй бөгөөд эдгээр 10 хавтас нь таны оюун ухаанд байрлах юм. Үүнийг л бид “Библийн Файл” гэж нэрлээд байгаа юм.

Эдгээр хавтас дотор сургалтын явцад олон төрлийн дэлгэрэнгүй мэдээлэл, түүх, баримт, газрын зураг орох болно.


гол дүрүүдийн хамт Библийн үндсэн санааг сурах болно. Библид буй олон хүн, үйл явдлыг энд дурдахгүй, зөвхөн үндсэн гол үйл явдал, хүмүүсийг дурьдах болно. Гэхдээ бусад үйл явдал, дүрүүдийн талаар та өөрөө дэлгэрүүлэн судлах орон зай нээлттэй бий шүү.

Библийн *Он тооллын хураангуйг* үзэх явцад **арван гол үг маань файлын үндсэн гарчиг** болсон ба тэдгээрийг нэг бүрчлэн дэлгэрүүлэх болно.


Суралцах явцдаа Библийн файл ба түүний доторх агуулгыг тогтоох каартыг ашиглаарай. Энэ каартыг хавсралт материал дээр багтаасан байгаа.

Одоо сургалтын **Хоёрдугаар хэсэг** рүү шилжье. Энэ хэсэгт Эртний Ойрхи Дорнодын газрын зургийг *цээжээр зурахад* суралцана. Үүний дараа **Гуравдугаар хэсэгт** Библийн Файл тус бүрийг дэлгэрүүлж үзэх болно. Ийнхүү үзэхдээ хоорондоо холбоотой түүхийг Библийн Файлд бичсэн дарааллын дагуу суралцана.


Ингэхдээ Библийн гол санаа: ***Бурханы Алдар Есүс Христийн сайн мэдээний үйлчлэлээр илчлэгдсэн тухай*** байн байн харах болно.




ХОЁРДУГААР ХЭСЭГ: ҮЙЛ ЯВДЛЫН ТАЙЗ ЭРТНИЙ ОЙРХИ ДОРНОДЫН ГАЗРЫН ЗУРАГ ЗУРАХ




Библийн үйл явдал өрнөсөн Эртний ойрхи дорнодын газрын зургийг та нэн удалгүй чадварлаг сурах болно! Энэ зурагт гарч буй 10 газар, 6 ус мөрөнг зурах хуудас хавсралтад бий. Алхам алхмаар дагаж зураарай. Хэд хэдэн удаа давтаж үзсэний дараа энэ зураг таны гарт орох болно.




1. Бичгийн цагаан цаас аваад (1) Босоогоор нь (2) Хөндлөнгөөр нь (3) нугалж (4) дэлгээрэй. Тэгвэл газрын зургийн тань уртаргаг, өргөрөг цаасны нугалаасаар гарсан байхыг та харарх болно.



2. Ойрхи дорнодын ус мөрний гол газруудыг зуръя. Цаасныхаа зүүн дээд болон баруун доод буланд хагас тойрог маягийн зураас гаргаарай.




3. ХОНЬЧНЫ ТАЯГ
 маягийн зураасыг баруун доод хагас тойргоос зүүн дээд хагас тойргийн наахна хүртэл зураарай. (Яг дууриалгаад зураарай)




4. Газар усны нэрийг тэмдэглэхдээ зөвхөн эхний үсгээр тэмдэглэхийг анхаарна уу.

Тухайлбал,
ЕМ = Ефрат мөрөн,
ГДТ = Газрын дундад тэнгис болон
ПБ = Персийн булан гэх мэтээр тэмдэглэх юм.




5. Зүүн доод буланд ТУУЛАЙН ХОЁР ЧИХ зураарай. (Туулайн толгой, нүүрийг гаргалгүй зөвхөн чихийг нь л зураарай.) Тэгээд түүн дээр **УТ** буюу “Улаан Тэнгэс” гэж тэмдэглээрэй.

Үйл
Явдлын
Тайз




Гарын Авлага хуул, 15-16
8.0.02.22

Үйл
Явдлын
Тайз



Гарын Авлага хуул, 15-16
8.0.02.26

Үйл
Явдлын
Тайз




Гарын Авлага хуул, 15-16
8.0.02.33


6. Яг туулайн чихнийхээ чанх дээр нь **ЗАГАСНЫ ДЭГЭЭ** маягийн дүрс зураарай. Доод хэсгийг нь **СТ** = Сөнөсөн тэнгис, дээд хэсгийг нь **ГН** = Галил нуур гэж бичээрэй. Галилаас эх авч Сөнөсөн тэнгист цутгадаг Иордан голыг тэмдэглэхгүй ч хаана байдгийг нь мэдэхэд хангалттай.

7. Гол мөрнөө зурчихлаа. Одоо 10 чухал газрыг тэмдэглэе. 10 газар нь **БАРУУН ГАР** талд нь 4 **ГАЗАР**, **ЗҮҮН ГАР** талд нь 6 **ГАЗАР** тэмдэглэх юм.

8. Таны талаас баруун гар талд байрласан 4 **ГОЛ ГАЗРЫГ** тэмдэглэе. Персийн булангийн дээр байрлах **У** = Калдейн хот УР, Ефрат мөрний дэргэд орших **В** = Вавилон, жаахан дээшээ яваад **Х** = Харан, баруун дээд өнцөгт **Н (А)** = Ассирийн нийслэл Ниневе хот.



9. Таны талаас зүүн гар талд дугуйлсан хэсэг дотор байрлах газрыг тэмдэглэе. Галил Нуур, Сөнөсөн тэнгэсийн гол дунд **К** = Канаан гэж тэмдэглээрэй. СТ-ийн хойд дээд үзүүр хавьцаа **И** = Иерусалим гэж бичээрэй. Иерусалимын эсрэг Иордан голын (таны талаас) баруун гар талд **Н.уул** = Небо уул.



10. Таны талаас зүүн гар талд дугуйлсан хэсэг дотор байрлах газрыг тэмдэглэе. Туулайн чихний яг голд **С.уул** = Синай уул, түүнээс үл ялиг дээш яваад **КБ** = Кадеш Барнеа. ГДТ-ийн урд үзүүр хавьцаа **Е** = Египет байрлаж байгааг тэмдэглээрэй.



11. Хамгийн сүүлд нь “Данаас Беершеба хүртэл” газар нутгийг Эзэн өгсөн гэдгийг тэмдэглээрэй. Тэдгээр нь Израилийн газар нутгийн хил хязгаар юм.

ГУРАВДУГААР ХЭСЭГ: ФАЙЛЫН ЗАДАРГАА

Файл бүрийн агуулгын задаргаа

Файл тус бүрээ 10 чухал үгээр тэмдэглэсэн билээ. Тухай бүрт “Өрнөх цэг” баганад хэсгүүдийг товчлон тайлбарласан хэсгийг багтаах болно. За ингээд файлаа нээж тэдгээрийн агуулгын задаргааг харцгаа!

Эхлэл 1-11



Цаг хугацаа:
Абрахамаас
өмнөх бүх
цаг үе.

Библийн Файлын “хамгийн эхнийх нь” **БҮТЭЭЛ** нэртэй файл юм. Файл бүр нь баруун талын баганад байгаагай адил хоосон байх юм. Тэдгээрийн доторх агуулгыг дээр нь бичиж бөглөнө.

Эхлэл номын эхний 11 бүлэгт зохиогч маань олон зууны турш үргэлжлэх олон үйл явдлыг маш товчлон хүргэсэн байгааг та анзаарсан байх. Энэ цаг үеийг 2000 МЭӨ гэж тооцож байгааг дашрамд хэлье. Үнэндээ тэр 11 бүлэг цаг хугацааны хувьд хичнээн их цаг хугацаа авсныг хэн ч хэлж мэдэхгүй биз ээ.

БҮТЭЭЛ хэмээх файл буюу хавтаст хүн төрөлхтөн бий болсон цагаас хойшхи бүх үндсэн гол зүйлийг дурьдсан байгаа.

Эхлэл 1-11 бүлэгт ямар ч алдаа мадаггүй эх сурвалжаас “**эхний**” гэх тодотголтой баримтыг харах болно. Мэдээж энд *бүх мэдээллийг* агуулаагүй ч чухал зүйлс бүгд бий.

БҮТЭЭЛ гэсэн хавтасны хоосон зайнд тэдгээр “эхний” гэсэн тодотголтой 7 зүйлийг бичээрэй.

Эхлэл номд буй “эхний” тодотголтой зүйлсийн жагсаалт

Өрнөх цэг

АНХААРУУЛГА!

Хавсралт 4-9 хуудас болон 31-р хуудсанд Файлын агуулгын задаргааг бүтэн бичсэн байгаа болно. Тэдгээр хуудсыг “семинар”-ын үеэр хэрэглэнэ үү.

Бүтээл

Өрнөх цэг

Эхний гэсэн тодотголтой
бүхнийг **ТОМ УСГЭЭР**
бичиж байгааг
анхаарна уу.

БҮТЭЭЛ
Эхний эр, эм
Эхний гэм
Эхний сайн мэдээ
Эхний гэр бүл

БҮТЭЭЛ
Эхний аллага
Үер / Солонго
Цамхаг

Эхлэл номд буй “эхний” тодотголтой зүйлсийн жагсаалт

• ЭХНИЙ ЭР, ЭМ

Бурханы бүтээсэн гэмгүй, төгс орчинд хүн төгс дүр төрхөөр бүтээгдэн аж төрж байлаа.

• ЭХНИЙ ГЭМ

Чөлөөт сонголтыг хүлээн авсан хүн соригдов. Төгс орчинд байсан тэрээр Сатанд соригдож, гэмд унав.

• ЭХНИЙ САЙН МЭДЭЭ

Хүний анхны төгс, гэмгүй, ариун байдал руу авчрах Аврагчийг илгээх тухай анхны амлалтаа Бурхан өгөв.

• ЭХНИЙ ГЭР БҮЛ

Адам, Ева хоёр үр хүүхэдтэй болж хүн төрөлхтөн оршин тогтнох үйл явцдаа Сатаны нөлөөгөөр Бурхан Эцэгтэй харилцаагаа сэргээхэд хүндрэлтэй тулгарч байв.

• ЭХНИЙ АЛЛАГА

Гэм нүгэл илүү гүнзгийрч Бурханы дүр төрхтэй хүн, Бурханы бэлэглэсэн амь насыг хөнөөх хүнд хэлбэрт шилжив.

• ҮЕР / СОЛОНГО

Бурхан өөрийн бүтээлээ газрын хөрснөөс арчиж, дахин эхлүүлэх шийдвэр гаргав. Бурханд үнэнч байж, зөвт амьдралаар амьдарсан Ноатай хамт нийт найман хүн амьд гарч бусад бүх хүн үеэрт (усан галав) үхэв. Үүний дараа хэзээ ч хүн төрөлхтөнийг усаар устгахгүй гэж амлалтын солонго татуулав.

• ЦАМХАГ

Хүн өөрийгөө Бурханы хэмжээнд өргөмжилж адил тэгш болох оролдлого хийв. Бурхан тэднийг өөр өөр үндэстэн болгохын тулд тэдний хэлийг самууруулав.

Библийн эхний номын эхний 11 бүлэгт саяын долоон зүйл гарч байна. Бурхан хүнийг ч, түүний амьдарч байсан газрыг төгс бүтээсэн юм. Хүн ийм л төгс орчинд нүгэл үйлджээ! Хүн өөрийгөө аварч чадахгүй учраас, хүний сул дорой байдалд тусалж байгааг Библи онцлон өгүүлдэг.

Дүгнэж хэлэхэд: **БҮТЭЭЛ** хэмээх файл нь Бурхан бол бүтээгч, хүн нүгэлд унасныг онцолж байна. Хүнийг анх л бий болгосон ариун төгс байдалд нь буцаан авчирч урьдын сайхан харилцаатай байхын тулд Эцэгийн хайраар Бурхан бидэнд хандаж байна. Бурхан руу буцан ирж буй түүх бол Библийн гол түүх, Сайн мэдээний цөм юм.

Библийн эхний номын цөөхөн хэдэн бүлэгт хүн төрөлхтөний асар их түүх, үйл явдал, Бурханы сайн мэдээ базагдан бичигдсэнийг та харж байна уу. За ингээд **Библийн файлын** эхний хавтас бүрэн боллоо.

БҮТЭЭЛ файлаас дараагийн файл болох **Библийн агуу дөрвөн хүний түүхийг** сөхөцгөө. Эхнийх нь хүн бол ...

Эхлэл 12-25



Цаг хугацаа:
2000 МЭӨ

(Дөрвөн хүний бүлгийн эхний хүн)

Дөрвөн хүнийг нэг бүлэгт оруулахад эхний хүн нь Бурханы найз **АБРАХАМ** болж байна. **Эхлэл 12-р** бүлгийн өмнө бүх юмыг товчхон өгүүлсэний дараа энэ бүлгээс авахуулаад **нэг хүний талаар, түүний ард түмний талаар буюу АБРАХАМ болон түүний үр удмын талаар** зохиогч өгүүлэх болно. Энэ нь Бурханы сонгосон ард түмэн буюу **Еврей хүмүүс** юм.

Нэг хүн, **АБРАХАМААР** өөрийн хүмүүсийг эргүүлж авчрах **үйл явц** эхэлж буйг та харах болно. **АБРАХАМААР** дамжуулан Библийн үндсэн бүх үйл явдлыг Илчлэлт ном хүртэл хэрхэн өрнөхийг Бурхан дэлгэн харуулах болно.

Өрнөх цэг

БҮТЭЭЛ
Эхний эр, эм
Эхний гэм
Эхний сайн мэдээ
Эхний гэр бүл
Эхний аллага
Үер / Солонго
Цамхаг

10 ФАЙЛ НЬ:

Бүтээл
АБРАХАМ
Иосеф
Моисе
Иошуа
Анархи
Хаанчлал
Колончлол
Чимээгүй үе
Есүс

АБРАХАМ

Өрнөх цэг

Эхлэл номын эхний хэсэг болон Илчлэлт ном нь цаг хугацааны алслалын хувьд маш чухал зүйлийг харуулна. Яг л уулын орой дээрээс алсыг харах шиг.



Библийн үйл явдал өрнөсөн Эртний ойрхи дорнодын газрын зураг

Абрахамын түүх эхэлсэн нь

Эхлэл 12 бүлгээс, **Он тооллын хураангуй** эхэлж байна. Ойрхи дорнодын үржилт шимт хөндий (өнөөгийн Иран, Иракт) энэ бүх үйл явдал өрнөсөн юм.

Библийн үйл явдлыг **2,000 МЭӨ** үед байсан болов уу гэж багцаалан тооцоолж байна. Энэ хичээлийн судлалаар үйл явдлуудыг 500 жилийн зайтайгаар авч үзсэн байгааг та анзаарах байх. Яг тодорхой цагийг хэн ч хэлж мэдэхгүй биз.

Үйл явдал Ефрат мөрнөөс Газар дундын тэнгис хүртэлх зайд өрнөж байгаа болно (Дээрх газрын зургийг харна уу.) Сайн мэдэх зарим нэрс гарч байгааг та анзаарч байна уу.

Абрахамын цаг үе:
2000 МЭӨ

Канаан (өнөөгийн Израиль улс оршиж байгаа), Галил нуур, Сөнөсөн тэнгис. Египет, Нил мөрөн. Синайн хойг зэрэг газрууд өнөөдөр ч дэлхий нийтийн анхаарлын төвд байдаг.

Яг энэ хэсэг газрыг “газрын хүй болсон” газар гэж нэрлэдэг. Энэ нутагт эртний цаг үед үеийн хаанчлал гарч ирээд, бөхдөг байв. Канаан/Палестин/Израиль тэр их дайны хөлд нэрвэгдэн дарамт шахалтыг байнга амсдаг байв.

Энэ их өргөн уудам нутагт, Библийн хэлсэн сүүлчийн өдрүүдийн томоохон үйл явдал өрнөх болно.

АБРАХАМЫН түүх Персийн булангийн дээхнэ орших **Калдейн Ур хотоос** эхэлдэг. Арабын ертөнцөд өнөөдөр ч энэ газар нилээн олон үйл явдал болж байгаа. МЭӨ 2000 жилийн өмнө Ур хот яахын аргагүй агуу хөгжилтэй, олон улсын худалдаа, урлаг, соёл, боловсрол, шашны төв болсон хот байлаа.

Настай **Тера** тэрхүү эртний **Калдейн Ур** хотод амьдарч байлаа гэж Библид хэлсэн.

Түүний хөвгүүдийн нэг **АБРАХАМ** (өөрийнх нь жинхэнэ нэр нь Абрам юм) байлаа. Түүний эхнэр **САРА** (өөрийнх нь жинхэнэ нэр Сарай). **АБРАХАМЫН** ахын өнчин хүү (ач дүү) **Лот** түүний гэр бүлийн гишүүн байлаа. **АБРАХАМ Бурханы дуудлагыг** хүлээн авч, түүнд зааж өгөх газар руу **УР** хотыг орхин явах хэрэгтэй болов.

Түүний бүх гэр бүл Эзэний чиглүүлэгийг даган хөдөллөө. Ногоон бэлчээр, усаа даган хойд зүг хөдөлж бүх мал ахуй, гэрээ нүүлгэн авч явав. Библид өгүүлснээр **АБРАХАМЫНХ** нилээн чинээлэг айл байсан юм.

Гол санаа нь: **АБРАХАМ** болон түүний гэр бүлийнхэн *Бурханы тэдэнд зааж өгөх газар руу* явсан явдал байв. **Калдейн Ур хотоос** гарахдаа тэд чухамхүү хаашаа нүүж яваагаа мэдээгүй юм. Бурханы хамгамж, хамгаалалтад итгэж дуулгавартай явсан нь л үнэхээр гайхамшигтай. Энэхүү гэр бүлийн гол гишүүд нь: **АБРАХАМ, түүний эхнэр Сара, эцэг Тера, болон түүний ач дүү (ахын хүүхэд нь) Лот нар байлаа.**

Өрнөх цэг


Түүхийн туршид “Ариун газар” болох Канаан/Палестин/Израиль нь стратегийн ач холбогдолтой газар байлаа.

АБРАХАМ
Дуудлага

Өрнөх цэг

Түүхийн туршид “Ариун газар” болох Канаан/Палестин/Израиль нь стратегийн ач холбогдолтой газар байлаа.

АБРАХАМ
Дуудлага



Канаан (өнөөгийн Израиль улс оршиж байгаа), Галил нуур, Сөнөсөн тэнгис. Египет, Нил мөрөн. Синайн хойг зэрэг газрууд өнөөдөр ч дэлхий нийтийн анхаарлын төвд байдаг.

Яг энэ хэсэг газрыг “газрын хүй болсон” газар гэж нэрлэдэг. Энэ нутагт эртний цаг үед үеийн хаанчлал гарч ирээд, бөхдөг байв. Канаан/Палестин/Израиль тэр их дайны хөлд нэрвэгдэн дарамт шахалтыг байнга амсдаг байв.

Энэ их өргөн уудам нутагт, Библийн хэлсэн сүүлчийн өдрүүдийн томоохон үйл явдал өрнөх болно.

АБРАХАМЫН түүх Персийн булангийн дээхнэ орших **Калдейн Ур хотоос** эхэлдэг. Арабын ертөнцөд өнөөдөр ч энэ газар нилээн олон үйл явдал болж байгаа. МЭӨ 2000 жилийн өмнө Ур хот яахын аргагүй агуу хөгжилтэй, олон улсын худалдаа, урлаг, соёл, боловсрол, шашны төв болсон хот байлаа.

Настай **Тера** тэрхүү эртний **Калдейн Ур** хотод амьдарч байлаа гэж Библид хэлсэн.

Түүний хөвгүүдийн нэг **АБРАХАМ** (өөрийнх нь жинхэнэ нэр нь Абрам юм) байлаа. Түүний эхнэр **САРА** (өөрийнх нь жинхэнэ нэр Сарай). **АБРАХАМЫН** ахын өнчин хүү (ач дүү) **Лот** түүний гэр бүлийн гишүүн байлаа. **АБРАХАМ Бурханы дуудлагыг** хүлээн авч, түүнд зааж өгөх газар руу **УР** хотыг орхин явах хэрэгтэй болов.

Түүний бүх гэр бүл Эзэний чиглүүллэгийг даган хөдөллөө. Ногоон бэлчээр, усаа даган хойд зүг хөдөлж бүх мал ахуй, гэрээ нүүлгэн авч явав. Библид өгүүлснээр **АБРАХАМЫНХ** нилээн чинээлэг айл байсан юм.

Гол санаа нь: **АБРАХАМ** болон түүний гэр бүлийнхэн **Бурханы тэдэнд зааж өгөх газар руу** явсан явдал байв. **Калдейн Ур хотоос** гарахдаа тэд чухамхүү хаашаа нүүж яваагаа мэдээгүй юм. Бурханы хамгамж, хамгаалалтад итгэж дуулгавартай явсан нь л үнэхээр гайхамшигтай. Энэхүү гэр бүлийн гол гишүүд нь: **АБРАХАМ, түүний эхнэр Сара, эцэг Тера, болон түүний ач дүү (ахын хүүхэд нь) Лот нар байлаа.**

Ур хотоос баруун хойд хэсгээр тэд явсаар эртний **Харанд** хүрч ирэв. Тэд **Харанд** хэсэг суурьших үед **АБРАХАМЫН** эцэг **Тера** өөд болов.

Бурхан **АБРАХАМД** тэнд байхад нь дахин үгээ хэлэв. Харан нутгаас гарч **Амласан Газар руу** явахыг тушаав. Тэр нь өнөөгийн Израил билээ.

Абрахам Бурханы Гэрээт Амлалтыг хүлээн авав

АБРАХАМ гэсэн файлын хажууханд дэлгэмэл номын дээр “**АГ**” гэсэн товчлол бий.

“АБРАХАМЫН ГЭРЭЭ”

Библийн гол үйл явдлын үйл явдал эндээс эхэлнэ. Итгэлийн дээдэс, илчлэлтийн эхлэл, хүмүүнд хандсан Бурханы шинэ хөтөлбөр эндээс эхэлж байгаа юм.

АБРАМТАЙ нөхцөл үгүй гэрээг Бурхан байгуулав. Энэхүү гэрээнд Библийн гол үйл явдал болсон гурван чухал зүйлийг багтаасан байжээ. Тэдгээр нь: **ГАЗАР, ҮР** хүүхэд болон **ЕРӨӨЛ**. Үүнийг бид **Г-Ү-Е** гэж товчлон **АБРАХАМ** хэмээн файлын даа тэмдэглэж байгааг анхаарна уу.

АБРАХАМЫН ГЭРЭЭНИЙ ГУРВАН АМЛАЛТ

- **ЭХНИЙ АМЛАЛТ: ГАЗАР** - үл хөдлөх хөрөнгө буюу өнөөг хүртэл Израилчуудын сууршин ирсэн, улс төрийн асар их ач холбогдолтой эх нутаг ийнхүү амлалтад багтав.
- **УДААХ АМЛАЛТ: ҮР ХҮҮХЭД** - удам залгах хүү. Амлалтад үр удам багтсан нь тухайн үед амлалт авахад өтөл болсон, үр хүүхэдгүй байсан **АБРАХАМ, САРА** хоёрт их ач холбогдолтой зүйл байв.
- **ГУРАВ ДАХЬ АМЛАЛТ: ЕРӨӨЛ** - Онцгойлон Абрахам, түүний удамд үүнийг амлав. Энэ амлалт

Өрнөх цэг




Эхлэл 12:1-3
Эхлэл 13:14-16
Эхлэл 15:9-18

АБРАХАМ
Дуудлага
Г - Ү - Е

Абрахамын гэрээнд багтсан амлалтууд:
• ГАЗАР
• ҮР ХҮҮХЭД
• ЕРӨӨЛ

Өрнөх цэг



Абрахам:
Харанаас Канаан уруу

Эхлэл 15:6*
Иаков 2:23

АБРАХАМ
<u>Дуудлага</u>
Г - У - Е
И - И

нь **АБРАХАМД** хүрээд, дараа нь газар дээрх бүх гэр бүлд хүрэх юм гэдгийг Бурхан амласан байна.

Библийн түүхийг бүхэлд нь ажваас **АБРАХАМЫН ГЭРЭЭНД** заагдсан амлалтууд биелж байгааг харж болно.

Ийнхүү гол үйл явдал тайзан дээр гарлаа!
АБРАХАМ 75 настай байхдаа **Амлагдсан Газар** нутагт хөл тавихад эхнэр **САРА** нь 65-тай байлаа. Ийм настай байхад нь Бурхан үр хүүхэд амлалаа гэж үү? Ийм насанд уу?

Тийм ээ, ийм насанд нь ингэж амлахад **АБРАХАМ** Бурханд итгэсэн юм. Ямар ч эргэлзээгүй *итгэсэн итгэлийнх нь хариуд* Бурхан түүнийг зөвт хэмээн тооцсон билээ. Ердөө л энгийн энэ итгэлээр! Бурхан хүмүүнд хандсан шинэ хөтөлбөрийнхөө эхлэлийг итгэлтэй, өөрийн хуучин анд* Абрахамаар ертөнцөд таниулав.

Он жилүүд өнгөрсөөр. **АБРАХАМ, САРА** хоёрт амласан хүү төрөөгүй л байв. Сарагийн тэвчээр барагдав. Египетээс авсан **Хагар** хэмээгч шивэгчнээ **САРА АБРАХАМД** өгч дундаас нь гарсан хүүхэд нь тэдэнд өгөх гэсэн амлалтын хүү ч юм бил үү хэмээн **САРАА** зөвлөв.

Хэлснээр нь ч, **Хагараар** дамжин **АБРАХАМ** эцэг болов. Хүүгийн нэрийг **ИШМАЕЛ** гэнэ. Харин **Бурханы амласан хөвгүүн энэ хүү биш** юм гэдгийг тэдэнд ойлгуулав.

Тэр үед **АБРАХАМ** 85-тай, **САРА** 75-тай байв.

Дахин 15 жил өнгөрөв. **АБРАХАМД** амласан хөвгүүн мэндэллээ! Түүний нэрийг **ИСААК** гэнэ (нэрийн утга нь “инээмсэглэл”). Тиймээ, өтөл болсон **АБРАХАМ, САРА** хоёрт шинэ хүү төрнө гэдэг үнэхээр инээдтэй явдал байлаа.

ИСААК, үнэхээр Бурханаас **АБРАХАМД** амласан удам залгах үр байлаа.

Ийнхүү, Абрахам хоёр хүүтэй болсон нь **ИШМАЕЛ - ИСААК** нар байлаа. (Үүнийг **АБРАХАМ** гэсэн файл дотор **И - И** гэж тэмдэглэв.) Ийнхүү орчин цагийн Араб Израилчуудын зөрчилдөөн тэртээ 4,000 жилийн тэртээ эхэлсэн юм. Арабууд **ИШМАЕЛ**ийг өөрсдийн өвөг дээдэс гэж үздэг бөгөөд Иудейчүүд

өөрсдийн өвөг дээдсийн удамд **ИСААК** гэж тооцдог билээ.

Эцэг нэгтэй, эх өөртэй хоёр хүүгийн дунд зөрчилдөөн байсан. **АБРАХАМ**ын гэрт байсан хэрүүл маргаан өнөөдөр ч газар нутаг хил хязгаар зэрэгцэн орших Араб Израилчуудын хооронд өрнөсөөр байна. Энэ хоёр үндэстэн хоёулаа **АБРАХАМ**ыг өөрсдийн өвөг дээдэс хэмээн тооцдог билээ!

Түүх энэ мөчөөс эхлэн нилээн өрнөнө!

Сара, АБРАХАМЫН дундаас төрсөн **ИСААК** үнэхээр Бурханы амласан хөвгүүн байлаа. Исаак дараа нь хоёр хүүтэй болсон нь: **ИАКОВ, ЕСАВ** байв (**И-Е** хэмээн **АБРАХАМ** файл дээр тэмдэглэв).

ИАКОВ бол **нөхцөл үгүй Амлалт** дагаж явах учиртай хүү байв.

ИАКОВ дараа нь **12 хүү, 1 охинтой** болов (Файл дотор 12 гэсэн тоогоор тэмдэглэсэн байгаа). 12 хөвгүүн нь Израилийн **12 овог** болжээ. Эдгээр хөвгүүдийн хоёр багын нэр нь: **ИОСЕФ** болон **Бениамин** нар юм.

Библийн файлын 3 дахь хэсэг рүү шилжье. Энэ нь **Хуучин Гэрээний 4 гол хүний нэг нь** юм. Түүний нэрийг ...

Эхлэл 37-50




(Дөрвөн хүний хоёрдах хүн)

ИАКОВ хүү **ИОСЕФЭЭ** үнэхээр их хайрладаг байлаа. Энэ хайр нь бусад хүүхдүүдийнх нь дунд агаархал төрүүлсэн нь илт байв. Ах нарынх нь үзэн ядалт **ИОСЕФ**ийн эсрэг хуйвалдаан болоод түүнийг Египет рүү тэмээн жин тууж яваа худалдаачдад боол болгон худалдсан байдлаас нь илт харэгддаг.

Египетэд очоод, **ИОСЕФ** үнэхээр чадварлаг, ухаалаг залуу гэдгээрээ танигдав.

Өрнөх цэг




10 ФАЙЛ НЬ:

Бүтээл
Абрахам
ИОСЕФ
Моце
Иошуа
Анархи
Хаанчлал
Колончлол
Чимээгүй үе
Есүс



Өрнөх цэг



Өнөр бүл үндэстэн
болтлоо өргөжив!



Түүний амьдралыг ийм өдрүүдэд нь ч хөтөлж буй Бурханы эрх мэдэл дор итгэмжтэй, дуулгавартай байснаар аливаад хурдан суралцаж байв. **ИОСЕФ** засаглалын төвшинд Фараоны зөвшөөрлөөр өндөр эрх мэдэлд хүрэв. **ИОСЕФ** Фараоны дараагийн хүн болж Египетийн газар нутагт өндөр албан тушаалд оров.

Яг энэ цаг үед Канаанд, газар орныг хамарсан их өлсгөлөн болж байлаа. Энэ их гамшигийг гэтэлгэхийн тулд **ИОСЕФИЙН** аав, өтөл болсон **ИАКОВ** (одоо Израил хэмээн нэр нь өөрчлөгдсөн) Канаанд байгаа бүхнээ **Египетэд** барин тусламж хүсэв.

Сонирхолтой хэд хэдэн үйл явдал өрнөсний дараа, Израилийн хөвгүүд, тэднийг угтаж авсан Египетийн их захирагч нь тэдний дүү **ИОСЕФ** болохыг танилаа. Ийнхүү хүү **ИОСЕФИЙН** урилгаар **Канаанд** байсан Израилийн бүх хүүхэд, албатууд Египет рүү нүүв. **Еврейчүүдийн гэр бүл** ийнхүү Египетэд **үндэстэн** болтлоо үржин олширч хожим нь **Израилчууд** хэмээн нэрийдсэн бөлгөө.

Иосефийн таньдаг захирагчдын дор тэд амар тайван амьдарч, хүндлэгдэн байв. Харин **ИОСЕФИЙН** үхлийн дараа тэд Египетийн **ЗАРЦ** болов.

Ийнхүү Египетэд очсон Еврейчүүд **430 жил боолчлогдов**. Асар хүнд дарамт дор тэд байсан ч хүн амын хувьд хурдтай өсөн үржин байлаа. Ийнхүү үржин олширсон нь Египетэд аюул занал мэт харагддаг болов.

Энэ хүртэл
үзсэнээ тоймлон
харья

Он тооллын хураангуй доторх **Библийн Файлд** юу юу өрнөснийг харж, тухайн файл бүрийн хоосон зайг “бөглөн” бичээрэй.

Библийн Файл

#1

БҮТЭЭЛ

Энэ файлд Бүтээгч Бурхантайгаа харилцаатай байсан хүний гэмгүй цаг үе, гэмд унасан үеийг багтаасан “**эхний**” гэх тодотголтой бүхнийг багтаан бичсэн байгаа.

Дараа нь **ДӨРВӨН ХҮНИЙ** нэр эхлэх ба эхэнд бичигдсэн нь Бурханы анд гэгдэх **АБРАХАМ** юм.

Библийн Файл

#2

АБРАХАМ

Калдейн Ур хотоос гарахыг Бурхан **АБРАХАМ**д хэлж түүнийг дуудна. Түүнд нөхцөл үгүй амлалт өгөх ба түүндээ **ГАЗАР, ҮР ХҮҮХЭД, ЕРӨӨ**Лийг багтаажээ. Үүнийг **АБРАХАМЫН ГЭРЭЭ** гэж нэрлэнэ. **АБРАХАМ**д хоёр хүү байсан бөгөөд тэднийг **ИШМАЕЛ, ИСААК (И-И)** гэдэг. **ИСААК** ч мөн хоёр хүүтэй бөгөөд тэднийг **ИАКОВ, ЕСАВ (И-Е)** гэнэ. **ИАКОВ** нь **12** хүүтэй ...

Библийн Файл

#3

ИОСЕФ

... тэдний нэг нь **ИОСЕФ**. Түүнд агаархдаг ах нар нь боолын худалдаачдад дүүгээ зарна. Ийнхүү **ИОСЕФ** Египетэд ирэх ба хожим нь их захирагч болно. Иаков гэр бүлээ Египетэд авчирснаар хожим агуу үндэстэн болтлоо үржинэ. **ИОСЕФ** үхэж, Израилчууд 430 жил Египетэд боолчлогдоно.

ТОЙМ

*Энэ хүртэл дүүргэсэн
Библийн Файл:*

БҮТЭЭЛ

Эхний эр, эм

Эхний гэм

Эхний сайн мэдээ

Эхний гэр бүл

Эхний аллага

Үер / Солонго

Цамхаг

АБРАХАМ

Дуудлага

Г - Ү - Е

И - И

И - Е

12

АГ

Өрнөх цэг

10 ФАЙЛ НЬ:

Бүтээл
Абрахам
Иосеф
МОСЕ
Иошуа
Анархи
Хаанчлал
Колончлол
Чимээгүй үе
Есүс

МОСЕ
Египетээс гарсан нь

Египетээс
гарсан нь
номоос
Дэд хууль
хүртэл

Библийн Файл
#4
МОСЕ

Цаг хугацаа:
МЭӨ 1500
оноос
тоологдоно

(Дөрвөн хүний гуравдах хүн)


Бурхан өөрийн таалсан цагт өөрийн босгосон хүн ардаа Египетээ боолчлолоос **чөлөөлсөн** юм. Чөлөөлөгч нь **МОСЕ** бөгөөд **Библийн Файлд түүнийг дөрвөн хүний гуравдах хүнээр** тэмдэглэдэг. Цаг хугацааны хувьд **МЭӨ 1500 оноос** эхэлж тоолно.

Олон зууны турш боолчлогдож байсан Израилчуудын дунд **МОСЕ** гэдэг хүн онцгойрон гарч ирдэг. Фараонд хэлэх түүний үндсэн шаардлага нь “Миний ард түмнийг чөлөөл!” байв. **МОСЕ**гийн шаардлагыг хүлээж аваагүй Египетэд 10 удаагийн гамшиг тохиолдсоны дараагаас л тэд Израилчуудыг чөлөөлж явуулна. **МОСЕ**гийн удирдлага дор боолын мөлжлөгө дор хэдэн үеэрээ байсан хоёр сая гаруй Израилчууд Египетээс гарах ба үүнийг “Египетээс гарсан нь” хэмээн түүхэнд тэмдэглэсэн байдаг. Тэд зарим хүний хэлдгээр Улаан тэнгисээр (англиар *the Red Sea*) гатлан гарсан гэдэг ч үнэн зөв хэллэг нь **Sea of Reed** хэмээх тэнгисийг туулан гарсан юм байна. Энэ их ус мөрөн нь Египет болн Синайн Хойгийн хооронд байрладаг байсан байж.

Энэхүү их ус мөрөнг голлон хувааж их мөрний сав газрыг хуурай болгон түүн дээгүүр нь Израилчууд чөлөөтэй алхан гарсан энэ гайхамшгийг Бурхан Израилчуудын төлөө үйлджээ. Тэдний араас илдэн хөөж байсан Египетийн цэргийн хүчнийхэн хуурай сав газраар гарч яваад гэнэтхэн эргэн хуйлран орж ирсэн тэрхүү их мөрний усанд живсэн тухай Библид өгүүлдэг.

Эсэн мэнд эргийн нөгөө талд гарсан Израилчуудын **МОСЕ** зүүн зүгт дагуулан явсаар **СИНАЙ УУЛ**ын бэлд авчирна. Энэ уул нь Синайн хойгт дүнхийнэ.

Энэ л газарт өөрийн **эхний** эш үзүүлэгч



МОСЕГЭЭР үгээ хэлсэн байна. Яг энэ газар **Хууль** буюу Еврейчүүдийн хэлдгээр **Тораг** өгчээ.

Мосед өгсөн Хууль нь дотроо гурван хэсэгтэй: **ЁС СУРТАХУУНЫ, ИРГЭНИЙ, ЁСЛОЛЫН.** Үүнийг бид **Ё-И-Ё** гэж **МОСЕ** гэсэн файл дээрээ тэмдэглээрэй.

ЁС СУРТАХУУНЫ хэсгийг **АРВАН ТУШААЛ** гэдгээр нь хүмүүс мэддэг. Энэхүү хууль нь өнөөдөр ч олон улсын хуулийн агуулгад байдаг.

ИРГЭНИЙ хууль нь цөлд байхдаа иргэд хоорондын харилцааг зохицуулах, мөн шинэ газарт орсны дараа ч иргэд хоорондын харилцааг зохицуулах зорилготой хууль юм. Энэ хуулийг авч байх үедээ тэд **40 жил** цөлд тэнүүчлэх юм чинээ санаагүй биз. Харин Бурхан тэдний өмнө ирж буй хүнд хэцүү он жилүүдийн төлөө энэхүү иргэний хуулийг бэлдсэн юм.

Харин **ЁСЛОЛЫН** хуульд цөлд баригдах Майхан сүмд болон хожим Иерусалимд баригдах сүмд хэрхэн Бурханыг дээдлэн хүндлэхийг заасан билээ. Энэхүү шинэ ёслол нь ирээдүйд хүн ба Бурханы хооронд бий болох харилцааг билэгдсэн олон билэгдлийг агуулсан байв.

Бурхан **МОСЕД** шинэ Хууль өгсний дараа, **МОСЕ** овгуудыг зохион байгуулж, Синайгаас хойд зүг рүү эргэж, тэднийг цөл дэх баянбүрд болох **КАДЕШ-БАРНЕА** буюу өнөөгийн Израилийн нутаг болох Негевийн цөл юм.

Эцэст нь, өвөг дээдэс нь болох **АБРАХАМ, ИСААК, ИАКОВТ** амласан **Амлагдсан Газарт** тэд буцав.

Энэхүү тэмдэглэлт өдөрт тэдний удирдагч **МОСЕ** бэлтгэхийн тулд *мэдээлэл* хэрэгтэй байв. Ажлаа сайн төлөвлөдөг аливаа хүнд мэдээлэл маш чухал. Мосе ийм л шалтгаанаар, шинэ газар нутгаа тандуулахаар тагнуулчдыг илгээсэн юм. Бид ямар газарт очих гэж байна? Хүн ард нь ямар юм? Гол мөрөн бий юу? Уул толгод? Ой мод? Тариалан эрхлэх талбай? Шууд очоод идэх хоол хүнсний нөөц хэр их байна вэ? гэх мэт асуултад хариулт авах хэрэгтэй байв.


Тиймд **КАДЕШ-БАРНЕАД** байрлангаа, **МОСЕ 12 овог** бүрээс төлөөлөх хүн гаргаж өгөхийг хүсэв. Төлөөлөгч болсон тэдгээр 12

Өрнөх цэг

МОСЕ
Египетээс гарсан нь
Синай
Ё-И-Ё

МОСЕГИЙН ГЭРЭЭНИЙ ТАЛААР ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ТУСЛАХ ГАРЫН АВЛАГЫН 15-Р ХУУДАСНААС ХАРНА УУ.

МОСЕ
Египетээс гарсан нь
Синай
Ё-И-Ё
Кадеш Барнеа



тагнуулд Канааныг тандах үүрэг өгөв. Тэд хойд зүгт өнөөгийн Ливан хүртэл тагнаад өмнө зүгт орших **КАДЕШ-БАРНЕАД** ирэв. Өөрсдийн тагнан мэдсэн бүхий л мэдээллийг тэдгээр тагнуулчид **МОСЕД** өгөв.

Тагнуулчдын **олонхийн дүгнэлт**: 10 тагнуулч хэлэхдээ, тэдний очсон **Амлалтын нутаг** бол “сүү, балаар бялхсан” байсан гээд. Даанч тэндхийн хүн ард нь биднээс том биетэй, бид тэдний өмнө царцаа мэт хүчээр жижигдэх юм гэж хэлэв. Тэд бол Бурханы чиглүүлгээр **Амлагдсан газрыг** эзлээд тэндээ амьдрах болно гэдэгт **итгээгүй 10 тагнуулч** байсан юм.

Хэдий тийм ч, үлдсэн хоёр тагнуулч нь (тэд бол **ИОШУА** болон **КАЛЕБ** нар байлаа) **цөөнхийн дүгнэлт** өгөв. Олонхийн хэлдэг үнээн. Гэхдээ, Бурханы тусламжтайгаар бид **Амлагдсан газар нутгийг** эзлэн авч чадна хэмээн тунхаглав!

Харин эдгээр дүгнэлтийг сонсож байсан хүмүүс Бурханы хамгаалалт, хамгамжинд итгэж байсан уу? Үгүй, тэд итгээгүй юм. Хүмүүс **олонхийн дүгнэлтэд** итгэж байлаа. Тэд айснаасаа болж Бурханы тодорхой төлөвлөгөө болон амлалтад итгээгүй юм. Хариуд нь, **МОСЕ** Канаан уруу цөмрөн орж, эзлэн авах тушаалыг өгөөгүй билээ.


Дуулгаваргүй байдлынхаа шанд, **цөлд 40 жил** тэнүүчлүүлэхээр илгээсэн юм. Ингэснээр гомдоллогч, дуулгаваргүй 20 настангуудаас дээш насалсан бүхнийг цөлд үхүүлсэн билээ. Энэ тоонд мэдээж, **ИОШУА, КАЛЕБ, МОСЕ** болон тэдгээрийн гэр бүл багтаагүй ээ.

Санаж явах чухал санаа энд явж байна: *Бурханы хамгаалалт, хамгамжид итгэхгүй, дуулгаваргүй байсныхаа төлөө тэд 40 жил* тэнүүчилсэн юм.

Тэд 40 жилийн турш Сөнөсөн тэнгисийн хажуугийн цөлд тэнүүчилсний дараа, Израилийн чөлөөлөгч, нас өндөр болсон **МОСЕ**гийн амьдралын сүүлчийн өдрүүд залгасан юм. Өөрийн дуулгаваргүй байдлаасаа болоод тэр ч мөн адил Канаанд орж чадаагүй юм.

40 жил өнгөрлөө. Үүний дараа **МОСЕД** Израилийн ард түмнийг Канаан уруу явуулах

МОСЕ
Египетээс гарсан нь
Синай
Ё-И-Ё
Кадеш Барнеа
40 жил



үүргийг өгөв.

МОСЕ нас эцэслэхийнхээ өмнө **ТАВАН (5) НОМЛОЛЫГ (Айлдварыг)** Небо уулын хормойд өгсөн юм. Израилчуудад Хуультайг нь сануулав. Тэдэнд бусад үндэстэнд байхгүй ер бусын өв буйг сануулав. Шинэ залуу үеийнхэнд тэдний Бурханы талаар, тэд хаанаас ирсэн хэн болох талаар, тэдний үнэт өв юу болох талаар, тэдэнд амлагдсан Газар нутгийг эзлэн авах ёстойг анхааруулав. Энэхүү **Таван Айлдварыг** “Дэд хууль” номд (Хоёр дахь хууль гэсэн утгатай) бичиж үлдээв.

Сургаалынхаа төгсгөлд, **ГАЗРЫН ГЭРЭЭ** гэгчийг **МОСЕ** ард түмэнд танилцуулав. Бурханы эртнээс амласан нөхцөл үгүй амлалтын дагуу **Газар** Израилчуудын өмч, үнэт өв болсон юм гэдгийг сануулав. Газрын Гэрээ нь **АБРАХАМЫН ГЭРЭЭНИЙ “Газар”** гэсэн амлалтын хэсгийг баяжуулж өгсөн гэрээ байлаа. **МОСЕ** тийнхүү түүхийн тайзнаас буув. **МОСЕ** хэмээх файл “ДХ” гэсэн үсэгтэй дэлгэмэл номын хэсгээр төгсч байгааг анхаарна биз ээ. “ДХ” нь Дэд Хууль буюу Газрын Гэрээ өгсөн хэсгийг сануулж байгаа юм.

Одоо бид **дөрвөн чухал хүний дөрөв дэх хүний файлыг** нээе. Түүний нэр бол ...

Иошуа
1-24



(Дөрвөн хүний дөрөв дэх хүн)

МОСЕгийн залгамж халааг авсан хүн бол Израилийн цэргийн агуу жанжин **ИОШУА** юм. Цөөнхийн (гэхдээ итгэмжтэй бүлгийн) дүгнэлт өгч байсан үеийг санаж байна уу? **ИОШУА** тэр хоёрын нэг байсан.

Нөхцөл тавилгүй **АБРАХАМЫН ГЭРЭЭНИЙ** дагуу **АБРАХАМД** амласан **Газар нутгийг** эзлэн авахад **ИОШУА** Израилийн хөвгүүдийг байлдаанд зохион байгуулсан гавьяатай нэгэн. Иордан голыг гатлан өнөө цагт туурь нь байгаа эртний Иерихо хотыг дайран тулалдсан юм. **МОСЕ** Египетээс

Өрнөх цэг


МОСЕ
Египетээс гарсан нь
Синай
Ё-И-Ё
Кадеш Барнеа
40 жил
5 Айлдвар




Дэд хууль 30:1-10

10 ФАЙЛ НЬ:

*Бүтээл
Абрахам
Иосеф
Мосе
ИОШУА
Анархи
Хаанчлал
Колончлол
Чимээгүй үе
Есүс*



Өрнөх цэг



Иошуа:

Газар нутгаа эзлэн авав.

ИОШУА

Иерихо / Аи

Газар хувиарлалт

Анх үзэж байсан
товчлолыг санаж
байна уу:

БҮТЭЭЛ

4 ХҮН

3 НИЙГЭМ

ЧИМЭЭГҮЙ ҮЕ

ЕСҮС

3 нийгэм нь:

Анархи

Хаанчлал

Колончлол

гарахдаа усыг хоёр хуваасны адил Иорданыг гатлахад адил тэмдэг бий болж Иордан гол хоёр тийш салж голын хуурай сав газраар цэргүүд нөгөө эрэгт гарсан билээ.

Тэр өдөр Израилчууд Канаан буюу өнөөгийн орчин цагийн нутагтаа ирсэн юм. Энэ бол тэдний өвөг дээдэс **АБРАХАМД**, Бурханаас амласан нутаг байв.

Эхлээд тэд гол хоёр хотыг эзлэн авав. Тэдгээр нь **ИЕРИХО**, **АИ** байв. Гэвч Бурханы тушаасны дагуу тэдгээр хотууд газрын хөрснөөс бүрэн арчигдсангүй. Бүрэн дуулгавартай байгаагүйн уршиг хожим нь их гай авчирдаг билээ.

ИОШУАгийн их тулаан 7 жил үргэлжилжээ. Үүний үр дүнд газар нутгаа тэд эзлэн авчээ. **Овог бүрт газрыг хуваасан** нь тэдний өвөг дээдэс **АБРАХАМД** өгсөн **ГАЗАР** өгнө хэмээх амлалтын биелэлтийн эхэн байлаа. Тэр газар үнэхээр үржил шимтэй, хүн оршин суухад таагай байв.

Одоо бид **ДӨРВӨН ХҮНИЙ** тухай бүрэн үзэж дууслаа. *Барагцаалсан хугацаа* болон эдгээр хүмүүсийн үйл явдлыг санаж байна уу. Энэ дөрвөн хүний амьдралыг 500 жилээр тооцож байгаа юм.

- **АБРАХАМ, ИОСЕФ:** Ойролцоогоор **МЭӨ 2000**
- **МОСЕ, ИОШУА:** Ойролцоогоор **МЭӨ 1500**

Библийн Файлын 4 ХҮН гэдгээс одоо 3 НИЙГЭМ хэсэгт шилжье. Тэдгээр нь:

**АНАРХИ
ХААНЧЛАЛ
КОЛОНЧЛОЛ**

Энэ хүртэл: **Газар нутгаа эзлэн авав ... Газрын хувиарлалт хийв ... хүн ард оршин суув.** Харин цэргийн агуу удирдагч **ИОШУА** нас барахад, Израилийн түүхэнд нэгэн том эргэлт болсон билээ.

Нэгдүгээрт, ард түмнийг удирдан зохион

байгуулах түүн шиг агуу удирдагч дахин гарч ирсэнгүй. Хүн бүр л өөрсдийн нүдэнд зөв гэж үзсэнээ хийдэг цаг үе гарч ирлээ*.

Хоёрдугаарт, нийгмийн болон шашны олон төрлийн асуудал ундарч ирэв. Шалтгаан нь: **ИОШУА** Израилчуудыг удирдаж байхдаа Бурханы тушаасны дагуу Канаанд байсан үндэстэн, ястан, тэдний шашин шүтлэгийг газрын хөрснөөс бүрмөсөн устгаагүй нь ийм байдалд хүргэв. Энэ мөчөөс эхлэн Канаанчууд Израилийн овгуудыг бага багаар хэмлэн сулруулав. Тэдний олонх нь Бурханаасаа эргэж, хөрш Канаанчуудын шүтээнд мөргөн завхайрцаав.

Энэ байдал нь гурван нийгмийн эхний нийгэмд хөтөлсөн юм ...

*Шүүгчид,
Рут*



(Гурван нийгмийн эхний нийгэм)

Израилчууд **Газар нутагтаа** суурьшин суусны дараа эмх замбараагүй нийгэм байгуулсан нь **АНАРХИ** (анархизм ч гэж ярьдаг) нийгэм байв.

Энэ нийгэмд Бурхан үе үе **ШҮҮГЧДИЙГ** босгон ирж байсан юм. Тэдгээр шүүгчид нь хүмүүсийг зөв замд оруулах, **Хуулийн** дагуу зөвт амьдрахад чиглүүлдэг байв.

ШҮҮГЧдийн үе бол *үндэсний урвалт шарвалтын үе* байв. Тэд Бурханы хүсэл, тушаалаас урваж шарвасан юм. Улс орны байдал сайн муу, дээшээ доошоо болж ер өөдлөхгүй тойрогт орсоор улам муудаж байлаа. Нөхцөл байдал улам дордоход Бурхан шинэ **ШҮҮГЧ**ийг гаргаж өгдөг байв. Нийтдээ **13 ШҮҮГЧ**ийг **АНАРХИ** нийгэмд гаргасан байдаг. Зарим нэгээс нь дурьдахад **Самсон, Гидеон**, мөн эмэгтэй шүүгч **Дебораг** таньж байгаа байх аа.

Сүүлчийн шүүгч нь **САМУЕЛ** байлаа.

Өрнөх цэг

*Шүүгчид 17:6

10 ФАЙЛ НЬ:

*Бүтээл
Абрахам
Иосеф
Моце
Иошуа
АНАРХИ
Хаанчлал
Колончлол
Чимээгүй үе
Есүс*





10 ФАЙЛ НЬ:

Бүтээл
Абрахам
Иосеф
Моце
Иошуа
Анархи
ХААНЧЛАЛ
Колончлол
Чимээгүй үе
Есүс

МОСЕгээс гадна САМУЕЛ бол Израилчуудын хувьд бичдэг, бичдэггүй эш үзүүлэгчдийн дундаас хамгийн урт хугацаагаар шүүсэн эш үзүүлэгч байв. Түүний амьдралаас **Эш Үзүүлэгчдийн цаг үеийг** тоолдог. Эш үзүүлэгчдийн цаг үеийг харвал тэд богино хугацаанд үйлчилж байсан.

Үндэстний хувьд хямран байсан тэр үед ард түмэн тэдний **ШҮҮГЧ** болох **САМУЕЛ** дээр ирж, бусад улс үндэстнүүдийн адил хаантай болгохыг хүслээ. **Самуелээр** дамжуулан Бурхан бол тэдний цорын ГАНЦ Хаан бөгөөд тэдэнд өөр хаан хэрэггүй гэж хэлүүлнэ. Харин хүмүүст энэ хариулт таалагдсангүй. Харин Бурхан Самуелээр дамжуулан, тэдэнд хүсээд байгаа хааныг нь томилж өг. *Тэнгэрийн* эрх мэдэл дор бус хүний захиргаа дор байх нь тэдэнд илүү хүнд байх болно гэдэг гашуун сургамжийг сурахыг зөвшөөрөв.

Нийтдээ **350** жил **АНАРХИ** нийгэм тогтсон юм. Самуел хоёр нийгмийн нүүр үзэж, АНАРХИ нийгмээс ард түмнийг **дараагийн нийгэм рүү** оруулав. Тэр нийгмийг бид ийнхүү нэрлэв ...

Түүхэн номууд:
1, 2 Самуел
1, 2 Хаад
1, 2 Шастир
Езра
Нехемиа

Яруу найргийн номууд:
Дуулал,
Сургаалт үгс
Соломоны дуун

Библийн Файл
#7
ХААНЧЛАЛ

Ойролцоогоор
МЭӨ 1000 он

Эш үзүүлэлийн номууд:
Исаиа, Иеремиа,
Иона, Амос, Хосеа,
Иоел, Мика, Нахум,
Хабаккук, Зефаниа

(Гурван нийгмийн хоёр дах нийгэм)

Цаг хугацааны хувьд ойртож **МЭӨ 1,000** он боллоо. **Самуел САУЛ**ыг хаан болгон томилсоноор **ХААНЧЛАЛ** хэмээх үе ирж байгаа юм. Нэгдсэн Израиль улсын гурван хаад бол **САУЛ, ДАВИД, СОЛОМОН**. Тэдний нэрийн эхний үсгээр тогтоовол их амар: **С-Д-С**.

САУЛ хаан болсны дараа, зовлонтой хүн

болж хувирсан юм. Бурхан **САУЛ**ын алдаа зөрчил, зан чанарын доголдол, үндэстнээ удирдаж буй байдал зэргийг нь харгалзан түүнийг хаан ширээнээс нь буулгасан билээ. Бурхан яг энэ үед нас өндөр болсон эш үзүүлэгч **Самуелийг нэгдсэн** Израилийн шинэ хааныг тослуулахаар түүнийг нэгэн айлд илгээв. Тэр бол Бетлехемд гэртэй, Иессегийнх байлаа. Түүний бага хүү, хоньчин **ДАВИД**, Израилийн дараагийн хаанаар тослогдов.

Ийнхүү “Бурханы зүрх сэтгэлийн араас явагч” хэмээгдэгч **ДАВИД** хаан **САУЛ**ын дараа хаан болох нь тэр. **ДАВИДЫН ГЭРЭЭ** түүнийг хаан ширээнд заларч байх үед байгуулагдсан билээ. Израилд амласан нөхцөл үгүй амлалтын дагуу, Израилийн хаан ширээнд түүний Хүү мөнхөд суух болно гэдгийг бататган амлав. Энэ нь үнэндээ Бурхан ба Түүний ард түмний хооронд гэрээлсэн Мессаиа Аврагчийн тухай яриа байв.


ДАВИДЫН ГЭРЭЭ нь **АБРАХАМЫН ГЭРЭЭНИЙ “ҮР ХҮҮХЭД”** гэдэг хэсгийг *баяжуулан бататгасан* билээ. Дэлгэмэл номын дээр “**ДГ**” (Давидын Гэрээ) хэмээн товчилсон үсгийг харна уу (баруун талын баганад буй).

ДАВИДын удирдлага дор *нэгдсэн ХААНЧЛАЛ* үнэхээр *Алтан Үедээ* байсан юм. **ДАВИД** Израилийн нийслэлийг **Иерусалимд** болгосон хүн юм. Эрт цагт **АБРАХАМ** хүү **ИСААК**ийг өргөх гэж байсан уул болох Мория ууланд **ДАВИД**ын хүү **СОЛОМОН** хожим **ИЕРУСАЛИМЫН СҮМИЙГ** барьсан юм. Энэхүү сүмийн үлдэгдэл болох Баруун Ханьг Иерусалим хотыг төсөөлсөн хүн бүр мэддэг. Яг энэ газар одоо Исламын Дугант Хад (Dome of the Rock) оршдог (42, 43-р хуудаст буй “Хавсралт 1 болон 2”-т буй зургийг харна уу).

ДАВИДЫН халааг **Батшебагаас** төрсөн **СОЛОМОН** авсан нь Израилийг нэг талаар улам хүчтэй болгосон юм.

СОЛОМОНЫ удирдлага дор нэгдсэн Израиль үндэстнийхээ хувьд хүчирхэгжин хөгжиж олон улсын тавцанд нэр хүндтэй улсын нэг болсон билээ. **СОЛОМОН** хаан мэргэн ухаан, уран барилга, асар их үнэ цэнээр улс орноо авч

Өрнөх цэг



2 Самуел 7:4-16
1 Шастир 17:3-15

- С-Д-С
- САУЛ
- ДАВИД
- СОЛОМОН

ХААНЧЛАЛ	
С - Д - С	
-- Хуваагдал --	
Хойд	Өмнөд
Израиль	Иуда
10	2
Эш үзүүлэгчид	
И-20	Р-20
_____	_____
_____	_____

явснаараа олон улсад ихэд нөлөөлсөн хүн юм. Гэвч хэн тэр бүх үнэ өртгийг төлсөн бэ? Асар их татварын дарамт, хүчээр хөдөлмөр эрхэлж байсан ард түмэн нь тэр бүх өртгийг төлсөн билээ.

Хэдийгээр мэргэн ухаантай гэгдэж байсан ч **СОЛОМОН** улс орноо дампууруулсан хүн юм. Олон улстай харилцахын хэрээр гадаад эхнэртэй болж тэдгээр нь өөр өөрсдийн шүтээнүүдийг Израильд авчирдаг байлаа. Тэр ч бүү хэл **СОЛОМОН** Бурханы Сүмийг барьж байгуулсаныхаа дараа хотын нөгөө захад байрлах шүтээний сүмүүдэд очиж мөргөл үйлддэг байв.

СОЛОМОН хааны нас эцэслэсний дараа **иргэний дайн** дэгдэж, нэгдсэн Израиль улс **хоёр ХУВААГДАХ** нь тэр.

Ийнхүү ХОЁР хуваагдсан нэгдсэн улс хоёулаа асар их нүглийг үйлдэн Бурханаас холдсон юм.

Арван овог нь ХОЙД Хаанчлал буюу **ИЗРАИЛЬ** гэж нэрийдсэн бөгөөд үлдсэн **хоёр овог нь (БЕНИАМИН, ИУДА овог) ӨМНӨД Хаанчлал** буюу **ИУДА** хэмээн нэрлэгдсэн болмой. **Хойд хаанчлал** нь ихэнх овгийг өөртөө багтаасан байсан учраас тэд **ИЗРАИЛЬ** хэмээн нэрээ авч үлдсэн юм байна.

ХААНЧЛАЛ хэмээх нийгэм үндэсний хуваагдлын дараа ч үргэлжилж байсан юм. Хуучин холбоотнуут, бусад үндэстнүүдийн шүтээнүүдийн мөргөл Израильд газар авсан нь **Хойд хаанчлалыг** мөхөхөд хүргэсэн юм.

Улс орны байдал улам дордсоор байсан тэр цаг үед **ЭШ ҮЗҮҮЛЭГЧИД** олноор гарч ирэн **ХОЙД, ӨМНӨД** хаанчлалын бусармаг явдлуудыг илчлэн хэлдэг байв. **МОСЕГИЙН ХУУЛЬ** уруу эргэж ирэхийг тэд давтан давтан ятгадаг байсан ч хуваагдлаас хойш **350** жилийн дараа улс бүрэн гадны **КОЛОНИ** болсон билээ.

Өмнөд, Хойд хаанчлал тус бүрт **20** хаад ээлж дараалан гарч ирсэн юм. **ИЕРОБОАМаар** эхэлсэн **20** хаад **ХОЙД** хаанчлалд, **РЕХОБОАМаар** эхэлсэн **20** хаад **ӨМНӨД** хаанчлалд гарч ирэв. **ХОЙД** хаанчлалын хаадыг **И-20**, **ӨМНӨД** хаанчлалын хаадыг **Р-20** гэж тогтоож болно.

ИЗРАИЛЬ нэрээ авч үлдсэн ХОЙД

ХААНЧЛАЛ улам бусармаг явдалд гаршиж, Бурханы хууль дүрмийг эсэргүүцэн амьдарч, эцэстээ **200** жилийн дараа АССИРЫН гарт орсон билээ. Ийнхүү хойд хаанчлал эргэж ирэхгүйгээр Ассир руу цөлөгдсөн юм. Тэднийг **Еврейчүүдийн их тархалт** ч гэж нэрлэдэг (Diaspora).

Энэ бүхэн **МЭ 722 онд** болсон билээ. Энэ оныг дараагийн хэлэх онтой тогтоож аваарай. Хойд хаанчлал ийнхүү тараагдсанаас хойш тэд хэзээ ч эх нутагтаа нэгдэн улс болохоор эргэн ирээгүй юм.

ИУДА нэртэй **ӨМНӨД ХААНЧЛАЛ** дээрх оноос хойш **150** жилийн дараа **ВАВИЛОНЫ Небухаднезар хааны** олз болов.

Улс гүрэн гүн хямарсан ийм цаг үед Бурхан эш үзүүлэгч **Иеремиагаар ШИНЭ ГЭРЭЭ**ний тухай үгээ хэлсэн билээ. Энэ бол *Бурхан газар дэлхий дээр оршигч хүн төрөлхтөнтэй ямар нэгэн нөхцөл тавилгүй шинэ төвшинд, шинэ хөтөлбөр хэрэгжүүлэхийн эхлэл байлаа.* Тийм ч учраас, **ИУДАГААС МЕССИАИ** ирэх юм гэсэн амлалт эртнээс өгөгдсөн байв. Тэр амлалтын дагуу Мессиаи дэлхийн хүмүүсийг нүглийн дарлалаас чөлөөлж Эцэг Бурхан анхан яаж л бүтээсэн тийм харилцаанд нь эргүүлэн авчрах юм.

Энэ нь АБРАХАМЫН ГЭРЭЭНИЙ ЕРӨӨЛ гэсэн хэсгийг баяжуулсан хэсэг юм. Дэлгэмэл номын дээр “**ШГ**” гэсэн товчлол **ХААНЧЛАЛ** гэсэн нийгэмтэй давхцан тэмдэглэхийг анхаарна биз ээ.


МЭ 586 онд (хоёр дахь чухал он тоолол энэ юм шүү) Иерусалим болон **СОЛОМОНЫ** барьсан агуу Сүм Вавилончуудын гараар нураагдав. **ӨМНӨД ХААНЧЛАЛ** болох **ИУДА** ийнхүү алдарт **ВАВИЛОНЫ КОЛОНИ** болж цөлөгдөв.

Өрнөх цэг

ХААНЧЛАЛ	
С - Д - С	
-- Хуваагдал --	
Хойд	Өмнөд
Израиль	Иуда
10	2
Эш үзүүлэгчид	
И-20	Р-20
200	350
Ассир	Вавилон




Иеремия 31:31-33



Израиль Ассирт, Иуда Вавилонд олзлогдов.

Хавсралт зураг 1: Соломоны барьсан Иерусалимын Анхны Сүм



Жич: Зураачийн уран төсөөлөл орсон болно. Зураач: Steve Miller

МЭ 1000 онд ЭЗЭНд Сүм (Өргөө) байгуулж өгөх санаа Давид хаанд төрсөн юм. Гэвч түүнийг нь барих хувь заяаг хүү Соломон хаан авсан билээ. ЭЗЭНий заасан Мориа уулан дээр Абрахам хүү Исаагаа өргөхөөр явсан газрыг Давид худалдан авч бэлдсэн байна. Өнөөдөр Иерусалимын сүмийн суурин дээр Исламчуудын Дугант Хад (Dome of the Rock) хэмээх бөмбөгөр алтан оройтой сүм оршиж байгаа билээ.

Энэхүү нүсэр байгууламж Ромын агуу бүтээн байгуулалтаас 500 жилийн өмнө байгуулагдсан юм. Хэдэн зууны турш нүүдлийн байдлаар авч явдаг Майхан сүмийг энэхүү барилгат сүмд нилээн эмх цэгцтэйгээр зохион байгуулан барьсан байна. Иерусалим дахь сүм нь Еврейчүүдийн шашин, улс төр, соёлын төв болсоор ирсэн билээ.

Хавсралт зураг 2: Өнөөгийн Иерусалимд буй Баруун Хана



<http://wallpaper.si/wp-content/uploads/2009/09/Western-Wall-and-Omar-Mosque-Jerusalem-Israel.jpg>

Орчин цагийн Иерусалимд, “Баруун хана” хэмээх нэртэй Соломоны барьсан Иерусалимын анхны сүм болон Херод хааны өргөтгөн барьсан хоёр дахь сүмээс үлдсэн нэгэн хана бий. Энэ хэсэг нь Еврейчүүдийг өвөг дээдсийнх нь өвтэй холбож буй онцгой нандин газар юм. Зурагт харагдаж байгаагчлан яг энэхүү хананы дээр Исламын Дугант Хад хэмээх сүм (Ал Акса Моск) оршдог ба энэ моск нь ч Мусалманчуудын ариун газрын нэг билээ.

Хэдэн зууны туршид энэхүү ханын чулууг хулгайлж, зээлж, эргүүлэн өгч, дахин барьж, шинэчлэн засварласаар иржээ. Энэхүү ханын доод хэсгийн чулуу нь одоо ч хагараагүй хэвээр үлдсэн бөгөөд үлдсэн дээрх хэсгийг нэмж хийжээ. Шүтлэгтээ үнэнч Еврейчүүд эдгээр чулуунуудын завсар залбирал бичсэн цаасаа чихэж шургуулж залбирдаг. Дэлхийн олон газарт буй өсвөр насны Еврей хүүхдүүд энэ хананы дэргэд очиж ирж буй цагийг билэгдсэн баярыг тэмдэглэдэг ажээ.

ТОЙМ

Энэ хүртэл дүүргэсэн
Библийн Файл:

БҮТЭЭЛ

Эхний эр, эм

Эхний гэм

Эхний сайн мэдээ

Эхний гэр бүл

Эхний аллага

Үер / Солонго

Цамхаг

АБРАХАМ

Дуудлага

Г - Ү - Е

И - И

И - Е

12

АГ

ИОСЕФ

Боолчлол

430 жил

ЗАВСАРЛАГА!

Энэ хүртэл
үзсэнээ тоймлон
харъя

Он тооллын хураангуй доторх Библийн Файлд юу юу өрнөснийг харж, тухайн файл бүрийн хоосон зайг “бөглөн” бичээрэй.

Библийн Файл
#1

БҮТЭЭЛ

Энэ файлд Бүтээгч Бурхантайгаа харилцаатай байсан хүний гэмгүй цаг үе, гэмд унасан үеийг багтаасан “эхний” гэх тодотголтой бүхнийг багтаан бичсэн байгаа.

Дараа нь ДӨРВӨН ХҮНИЙ нэр эхлэх ба эхэнд бичигдсэн нь Бурханы анд гэгдэх АБРАХАМ юм.

Библийн Файл
#2

АБРАХАМ

Калдейн Ур хотоос гарахыг Бурхан АБРАХАМд хэлж түүнийг дуудна. Түүнд нөхцөл үгүй амлалт өгөх ба түүндээ ГАЗАР, ҮР ХҮҮХЭД, ЕРӨӨЛийг багтаажээ. Үүнийг АБРАХАМЫН ГЭРЭЭ гэж нэрлэнэ. АБРАХАМд хоёр хүү байсан бөгөөд тэднийг ИШМАЕЛ, ИСААК (И-И) гэдэг. ИСААК ч мөн хоёр хүүтэй бөгөөд тэднийг ИАКОВ, ЕСАВ (И-Е) гэнэ. ИАКОВ нь 12 хүүтэй ...

Библийн Файл
#3

ИОСЕФ

... тэдний нэг нь ИОСЕФ. Түүнд атаархдаг ах нар нь боолын худалдаачдад дүүгээ зарна. Ийнхүү ИОСЕФ Египетэд ирэх ба хожим нь их захирагч болно. Иаков гэр бүлээ Египетэд авчирснаар хожим агуу үндэстэн болтлоо үржинэ.

ИОСЕФ үхэж, Израилчууд 430 жил Египетэд боолчлогдоно.

Библийн Файл

#4

МОСЕ

МОСЕ Израилийн **ЧӨЛӨӨЛӨГЧ** Египетээс гарахад удирдан зохион байгуулагч, Урт тэнгисийг гатлан **СИНАЙ УУЛАНД** авчраад, **ХУУЛИЙГ** өгсөн эш үзүүлэгч юм. Тэр хууль нь дотроо гурван хэсэгтэй бөгөөд эхнийх нь **АРВАН ТУШААЛ** байв. Тэндээс дээш яваад **КАДЕШ-БАРНЕАД** ирээд **12** тагнуулыг **ГАЗАР** нутгийг тагнуулахаар илгээв. Бурханы хангамжид эргэлзсэн Израилчуудад айдас, итгэлгүй байдал, дуулгаваргүй байдал байсны улмаас **40 жил** тэд цөлд тэнүүлчилжээ. Амьдралынхаа эцэст **МОСЭ 5 АЙЛДВАРЫГ** Израилийн шинэ үеийнхэнд айлджээ. Үүнийг **Дэд хууль** номонд бичсэн бөгөөд, тэнд нөхцөл дурьдалгүй амласан **ГАЗРЫН ГЭРЭЭГ** өгөв. **МОСЕ** нойрсов.

Библийн Файл

#5

ИОШУА

Цэргийн удирдагч **ИОШУА** Израилчуудыг удирдан Иордан голыг гатлан **Амласан Газраа** авах **7 жилийн** дайныг өрнүүлэв. Газраа эзлэн авч овгуудад **хуваан** өгч **АБРАХАМД** амласан **ГАЗАР** гэсэн хэсгийг биелүүлэв.

Библийн Файл

#6

АНАРХИ

350 жил Газар дээрээ амьдарч байсан авч гол удирдагчгүй байв. Овог бүр өөрийнхөөрөө дураараа авирлаж, сайн муу байдалтай байлаа. Үе үе **ШҮҮГЧ**дийг Бурхан гарган зөв замд нь оруулна. Израилийн сүүлчийн агуу **ШҮҮГЧ** нь **САМУЕЛ**.

Өрнөх цэг

МОСЕ

Египетээс гарсан нь

Синай

Ё-И-Ё

Кадеш Барнеа

40 жил

5 Айлдвар

ДХ

ИОШУА

Иерихо / Аи

Газар хувиарлалт

АНАРХИ

Шүүгчид

350 жил

ХААНЧЛАЛ	
С - Д - С	
- - Хуваагдал - -	
<u>Хойд</u>	<u>Өмнөд</u>
<u>Израиль</u>	<u>Иуда</u>
<u>10</u>	<u>2</u>
<u>Эш үзүүлэгчид</u>	
<u>И-20</u>	<u>Р-20</u>
<u>200</u>	<u>350</u>
<u>Ассир</u>	<u>Вавилон</u>

ДХ

ШГ

Библийн Файл
#7
ХААНЧЛАЛ

Бурхан **Самуелд** Израилийн анхны хаан **САУЛЫГ** томилохыг зөвшөөрнө. Гэвч тэр муу хаан болсон тул түүнийг сольж, тун удалгүй **ДАВИДЫГ** хаанаар тосолно. **ДАВИДЫН** “Алтан Үе” эхэлнэ. **ДАВИДААР** Бурхан **ДАВИДЫН ГЭРЭЭГ** тунхаглуулна. Түүний залгамж халааг хүү **СОЛОМОН** нь авна. Түүний хүсэл нь өөрт нь ч, Израильд ч гай авчрах бөгөөд түүнийг үхсэний дараа иргэний дайн дэгдэж улс нь хоёр хуваагдана. Иргэний дайны үеэр эш үзүүлэгээ *бичдэг* эш үзүүлэгчид олноор гарч ирнэ. **Нэгдсэн Израиль Хойд (Израиль), Өмнөд (Иуда)** гэж задрах ба хоёулаа бусад улсын **КОЛОНИ** болж цөлөгдөнө. Яг энэ үед **ИЕРЕМИАГААР нөхцөл дурьдаагүй ШИНЭ ГЭРЭЭГ** өгч, Мессиаи удахгүй ирэх болно гэдгийг эш үзүүлдэг.

За одоо **ГУРВАН НИЙГЭМ** хэсгийн сүүлчийн нийгэм болох **КОЛОНИЙН** нийгмийг үзье. Энэ бол **Библийн Файлын 8 дахь** нь билээ.

Түүхэн номууд:
Езра, Нехемиа,
Естер

Библийн Файл
#8
КОЛОНЧЛОЛ

Он тоолол
МЭӨ 586 он

Эш үзүүлэгчид
Обадиа, Езекиел,
Даниел, Зехариа,
Хаггаи, Малахи

(Гурван нийгмийн гурав дах нийгэм)

ХОЙД болон **ӨМНӨД хаанчлал** хоёулаа колончлогдсон ч тэдний хувь заяа өөр өөр байсан юм. **ИЗРАИЛЬ** нэрээ авч үлдсэн **ХОЙД хаанчлал** бусад үндэстэн дунд тарж бутраад эх нутагтаа эргэж ирээгүй. Харин **ИУДА** буюу **ӨМНӨД Хаанчлал** нь **Иудейчүүдийн** урт удаан түүхийн халааг үргэлжлүүлэн авч явсан юм. Тэдний хувьд колончлол нь *түр зуурын* үйл явдал байсан билээ.

Яагаад? Олон эш үзүүлэгчдийн өгүүлсэнээр **Мессиа** нь **ИУДА** нэртэй овгоос ирэх байв.

ИУДА 70 жилийн турш Вавилонд олзлогдов (Персийн булангаас дээш ойрхи дорнодод байрлах өнөөгийн Ирак юм). **70 жилийн дараа** Вавилоны шинэ хаан **ӨМНӨД ХААНЧЛАЛ ИУДАГ** эх нутагтаа буцахыг зөвшөөрөв. Тэд ийнхүү **Иерусалимдаа** буцан ирж, өөрсдийн Сүмээ сэргээн босгох боломжтой болсон билээ.

Цаг тооны хувьд МЭӨ 500 оны тухай яриад байна. Бүтэн **100 жилийн** хугацаанд **Вавилоноос эх нутагтаа 3 удаагийн нүүдлээр** Иудейчүүд эргэн иржээ. Энэ нүүдлээр нийт **50,000** Иудейчүүд буцан ирсэн юм. Энэ цаг үеэс л **ИУДАГ Иудейчүүд** (Иудейчүүд гэдэг нь **ИУДА** аймгийн нэрээр бий болжээ) хэмээн нэрлэсэн билээ.

Вавилоноос нутагтаа эргэж ирэх хүнд ажлыг удирдан явсан гурван удирдагчийн нэрийг мэдэх учиртай. Тэдний нэрс бол:


- **ЗЕРУББАБЕЛ**
- 3-Е-Н: • **ЕЗРА**
- **НЕХЕМИА**

Вавилонд олзлогдсон Иудейчүүд бүхэн эргэж ирээгүй юм. Олонх нь тэндээ бизнесээ

Өрнөх цэг

10 ФАЙЛ НЬ:

Бүтээл
Абрахам
Иосеф
Моце
Иошуа
Анархи
Хаанчлал
КОЛОНЧЛОЛ
Чимээгүй үе
Есүс



Иуда Вавилоны колончлолоос эргэж нутагтаа ирсэн нь

Өрнөх цэг

КОЛОНЧЛОЛ

70 жил

3 Нүүдэл

100 жил / 50,000

3 - E - H

10 ФАЙЛ НЬ:

Бүтээл

Абрахам

Иосеф

Мосе

Иошуа

Анархи

Хаанчлал

Колончлол

ЧИМЭЭГҮЙ ҮЕ

Есүс

ЧИМЭЭГҮЙ ҮЕ

Грекийн Александр

Ромын систем

амжилттай эрхэлж, орон гэрээ төвхнүүлсэн болохоор явсангүй. Гэвч тэд санхүүгийн дэмжлэг үзүүлэн нутаг буцагсдад байнга тусалж байлаа.

Хойд Хаанчлал болох Израил

үндэстнүүдийн дунд тархан амьдарч, харин Өмнөд Хаанчлал болох Иуда эх нутагтаа эргэн ирсэн юм.

Ийнхүү Библийн Файлын маань КОЛОНЧЛОЛ хэмээх файл бүрэн боллоо! Ес дэх файлаар Библийн Хуучин Гэрээний түүх төгсөж байгаа юм.

*Малахи номоос
Матай ном
хүртэл*

Библийн Файл

#9

ЧИМЭЭГҮЙ ҮЕ

*Он тоолол
МЭӨ 500 оноос
Есүс мэндлэх
хүртэл*

Маш богино хугацаанд дэлхий ертөнц (үйл явдлын тайз) асар их өөрчлөгдөнө. Бидний хэрэглэж буй Протестант Библийн **Хуучин болон Шинэ Гэрээний** хоорондох **400 жилийг “Чимээгүй үе”** гэж нэрлэж байгаа юм. Чимээгүй үе гэдэг нь энэхүү завсрын үед Бурхан ямар нэг илэрхийлэл өгөөгүй гэсэн утгатай билээ.

Яг энэ хугацаанд дэлхийн түүхэнд томоохон үйл явдал болдог. Энэ цаг үед **ГРЕКИЙН АГУУ АЛЕКСАНДР** дэлхийн түүхэнд гарч ирснээр өөрийн мэдэх газар нутгийг асар богино хугацаанд эзлэн авна. Эзлэн авсан нутаг бүрт **Грек хэл, соёл** буюу **Хелленизмыг** бий болгоно. Библийн файлд **ГРЕКИЙН АЛЕКСАНДР** гэж тэмдэглээрэй.

АЛЕКСАНДР тайзнаас буухад **РОМЫН ЭЗЭНТ ГҮРЭН** дэлхийн түүхнээ нийгэм ба цэргийн зохион байгуулалттай, хууль, харилцаа болон замын **СИСТЕМТЭЙ** үеийг танилцуулан гарч ирнэ. Харгис ч гэсэн амар тайван **Ромын Энхтайван (Pax Romana)** хэмээх системээр дэлхий нэг хэсэг амрав.

Грекийн соёлын довтолгоо хийсэн бол Ром нийгмийн хөгжингүй системийг бий болгосон юм. Ийнхүү бүх үеийн турш хүлээлгэсэн Агуу

Нэгэн ирэхэд дэлхий ертөнц бэлэн болжээ!

За бид Библийн Файлын сүүлчийн файлд тулж ирлээ. Өмнө нь үзсэн бүх түүх энэхүү сүүлчийн файлын гол хүний төлөө өрнөн хөгжиж ийнхүү оргилдоо хүрлээ!

ШИНЭ ГЭРЭЭ:

Матай, Марк,
Лук, Иохан,
Үйлс, Захидууд,
Илчлэлт

Библийн Файл

#10

ЕСҮС

Он тоолол

Есүсийн газар
дээрх амьдрал ба
үйлчлэл
МЭӨ 4/5 оноос МЭ
33 он хүртэлх үе

Дэлхийн бүх хүнд **сайн мэдээг** илчлэх Есүс Христийн айлчлалыг Бурхан Эцэг төлөвлөсөн цаг ийнхүү ирсэн юм. Ийнхүү алдагдсан харилцаагаа сэргээж **өөрийн хүмүүсийг эргүүлэн авах** Бурханы авралын төлөвлөгөө бүрэн илчлэгдлээ!

Шинэ Гэрээ Аврагч ЕСҮСИЙН дэлхийд мэндэлсэн тухай гэрчилж эхэлдэг. 2,000 гаруй жилийн өмнө нөхцөл тавилгүй **АБРАХАМТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ** хэрхэн ийнхүү биелж байгааг та харж байна уу?

ЕСҮС хэмээх файлыг үндсэн гурван хэсэгт хувааж болно:

- 1) Түүний **АМЬДРАЛ**
- 2) Түүний **ЗАГАЛМАЙН** ач холбогдол
- 3) **ЧУУЛГАНЫ** эхлэл.

Түүний **АМЬДРАЛЫГ** дараах байдлаар нарийвчлан харж болно:

- Түүний **бага нас**
- **Иерусалимд** хийсэн эхэн үеийн үйлчлэл
- **Галил** уруу чиглэсэн үйлчлэл
- **Капернаумд** төвлөвсөн Галил дахь үйлчлэл
- **Пери** дэх үйлчлэл, эцэст нь
- Түүний амьдралын **сүүлчийн 7 хоног**, **Иерусалим** дахь сүүлчийн үйлчлэл.

ЗАГАЛМАЙН ач холбогдлыг **СҮҮЛЧИЙН ЗООГ** дээр **ШИНЭ ГЭРЭЭНИЙ ЭХЛЭЛ** гэж хэлээд загалмай дээр **“За гүйцлээ!”** гэж хэлснээр дүгнэн харж болно.

ЗАГАЛМАЙ гэдэг файлд бид Түүний

Өрнөх цэг

10 ФАЙЛ НЬ:

Бүтээл
Абрахам
Иосеф
Мосе
Иошуа
Анархи
Хаанчлал
Колончлол
Чимээгүй үе
ЕСҮС

ЕСҮС

Амьдрал

Загалмай

Чуулган

сүүлчийн хэдэн цагийн үйлчлэлийг тодорхой харах хэрэгтэй юм. Тухайлбал, ЕСҮСИЙН - **Үхэл, Оршуулга**, ялгуусан **Амилалтыг** оруулах шаардлагатай.

ЧУУЛГАН гэдэг файлд “*еклешиа*” (*тусгаарлагдан дуудагдсан нэгэн*) хэмээх ойлголтыг задалж харж байгаа болно. Иерусалимд Иаков, Петр нар байхад бусад үндэстэнд Паул, Лук, Барнаб болон бусад хүнийг дурьдаж дэлгэрүүлж болно.

Энэ бүхэн **Сайн мэдээний 4 ном** болон **элч нарын Үйлс** номд дэлгэрэнгүй бичигдсэн буй. Үйлс номын араас олон **Захидлуудыг** анхны чуулганд заавар, чиглүүлэг, сургаал, дэмжлэг өгөхөөр элч нараар бичигдсэнийг та унших болно. Эдгээр захидлууд нь анхны **ЧУУЛГАН**ыг хэрхэн ажиллаж, дотоод гадаад асуудалд хэрхэн хандахыг зааж өгч байсан байна.



Теологич Жон Валвүүрд ийнхүү бичжээ: “*Энэхүү Библийн бүхэл агуулга эцэстээ Илчлэлт номын гайхалтай дүгнэлтэнд хүрч байна. Тэнд, мянган жилийн хаанчлалд бүхий л түүхийн урсгал болон Бурханы нөхцөл үгүй гэрээ хамтдаа бүрэн цутгаж байгаа юм. Амлагдсан бүх зүйлс төгс биелэгдлээ. Бурхан ба түүний найз, Абрахамын хооронд байсан эртний бүхий л ойлголтууд төгс биелж байна*”

АБРАХАМЫН ГЭРЭЭНД тусгагдсан гурван амлалт бүгд ийнхүү биеллээ: **ГАЗАР, ҮР ХҮҮХЭД, ЕРӨӨЛ**.

• **Израиль ДЭД ХУУЛЬ** буюу **ГАЗРЫН ГЭРЭЭНИЙ** дагуу **Амлагдсан газраа** бүрмөсөн эзлэн авсан билээ.

• **ЕСҮС ХРИСТ** бол **ДАВИДЫН** удмаас төрсөн зөвт **ҮР ХҮҮХЭД** байсан билээ. Иерусалимд үүрд мөнхөд өөрийн хаанчлалыг Тэр байгуулсан юм. Энэ бүхэн нь **ДАВИДЫН ГЭРЭЭНИЙ** дагуу биелсэн билээ.

• Бүх хүн бүр **ЕРӨӨЛИЙН** дор амьдарч байгаа нь бидний Эзэн **ЕСҮС** газар дээр байсных бөгөөд Тэр **ШИНЭ ГЭРЭЭ**ний биелэл болсон юм.



ЕСҮС хэмээх файлд буй бүхэн нь бидний Христитгэлт амьдрал, бидний энэ хүртэл судалсан судалгаа, уншсан бүх мэдээлэл, бодол, залбирал, амьдралын туршлага, итгэлээр төлөвших явц зэрэг нь энэ цэгт төвлөрч бүгдийг ойлгомжтой болгож байна.

ЧУУЛГАН хэмээх файлд зөвхөн анхны чуулганы тухай ч бид уншиж байгаа юм биш. Бид өөрсдийгөө ч мөн эндээс унших боломжтой. Учир нь ЧУУЛГАН өнөөдөр ч Агуу Захирамжийг биелүүлсээр байгаа билээ. Бид анхны чуулганаас суралцаж дахин эргэж ирэх Есүсийн ирэлт хүртэл яаж амьдарч байх ёстойгоо захидлуудаас харах учиртай юм.

Библи салангид бус харин *нэгдмэл ном* юм гэдгийг ЕСҮС хэмээх файл гэрчилж байна. Хуучин Гэрээний тэр бүх илчлэлтүүд ЕСҮСийг зааж байна. Есүстэй холбогдсон бүхэн авралыг хүлээн авч, бүх талаараа Түүнтэй адил болж төлөвших учиртайг Бурханы Үг бидэнд тодорхой зааж өгөх болно!

10 гол үгс бүхий

Файл:

**БҮТЭЭЛ
АБРАХАМ
ИОСЕФ
МОСЕ
ИОШУА
АНАРХИ
ХААНЧЛАЛ
КОЛОНЧЛОЛ
ЧИМЭЭГҮЙ ҮЕ
ЕСҮС**

БҮТЭЭЛ

Эхний эр, эм

Эхний гэм

Эхний сайн мэдээ

Эхний гэр бүл

Эхний аллага

Үер / Солонго

Цамхаг

АБРАХАМ

Дуудлага

Г - Ү - Е

И - И

И - Е

12

АГ

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: БИБЛИЙН ТҮҮХИЙГ ТОВЧООР

Сурсан бүх зүйлээ дүгнэх цаг болжээ. Бид **10 чухал үгээр** эхэлсэн, тэдгээрийг одоо цээжээр хэл дээ. **ОН ТООЛЛЫН ХУРААНГУЙГ** гэрлийн хурдаар та одоо хэлж чадна. Өөрөөр хэлбэл, *Библийн гол санааг*. Тэгээд энд байгаа бүхнийг харалгүйгээр цээжээр бүгдийг хэлэх гэж оролдвол бүүр сайн. *Оюун ухаандаа Библийн Файлыг* бүтээж байгааг санаж байгаа байх гэж итгэж байна. Тэгээд Библийн файлаа нээж хавтас тус бүрийн доторх хэсгүүдийг нэрлээрэй.

ОН ТООЛЛЫН ХУРААНГУЙГ ХУРДАН ХУГАЦААНД ХЭЛБЭЛ!

Библийн Файл

#1

БҮТЭЭЛ

Хэлж мэдэхгүй олон мянганы түүхийг **БҮТЭЭЛ** хэмээх файлд өгүүлжээ. Эхний гэх тодотголтой бүхнийг энд өгүүлнэ.

Библийн Файл

#2

АБРАХАМ

Калдейн Ур хотод Бурхан **АБРАХАМЫГ** дуудна. Эхнэр **САРА**, Лот эцэг **Терагийн** хамт тэр хотоос тэд явна. Эртний **ХАРАНД** иртэл эцэг **Тера** нь өөд болно. Тун удалгүй тэд **Канаан** руу нүүнэ. **АБРАХАМ** хоёр хүүтэй: **ИШМАЕЛ**, **ИСААК (И-И)**. **ИСААК** мөн хоёр хүүтэй: **ИАКОВ**, **ЕСАВ (И-Е)**. **ИАКОВ 12 хүүтэй** ба тэд улмаар **Израилийн 12 овгийн эцгүүд** болсон юм. **АБРАХАМ** ба түүний удмаар Бурханы агуу амлалтууд болох **ГАЗАР**, **ҮР ХҮҮХЭД**, **ЕРӨӨЛ**ийг багтаасан **АБРАХАМЫН ГЭРЭЭ** биелсэн билээ.

Библийн Файл

#3

ИОСЕФ

12 хөвгүүний нэг **ИОСЕФ**, атаархуу ах нарынхаа хуйвалдаанаар Египетэд боолын худалдааны золиос болов. Тэр боолоос, агуу их захирагч болтлоо дээшилсэн юм. **ИАКОВЫН гэр бүлийнхэн** өлсгөлөнгөөс зугтаж, **ИОСЕФ**ийн урилгаар **Египетэд** нүүж ирэв. Тэд тэндээ өнөр олуулаа болсон юм. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр тэд **Египетэд** **БООЛ** болж нэг мэдэхэд **430 жилийг** тэнд өнгөрүүлжээ.

Библийн Файл

#4

МОСЕ

Боолчлолд байхад **МОСЕ** тэдний дундаас гарч ирээд, **Египетээс гарах** түүхэн явдлыг удирдсан хүн билээ. Египетээс **СИНАЙН ХОЙГТ** орших Синай ууланд очиж, Бурханаас **ХУУЛЬ** (Еврейгээр ТОРА) авав. Тэр хууль нь гурван хэсэгтэй бөгөөд дотроо **ЁС СУРТАХУУНЫ, ИРГЭНИЙ, ЁСЛОЛЫН (Ё-И-Ё)** ангилагддаг. **МОСЕ** Израилчуудыг тэндээс удирдан **КАДЕШ-БАРНЕА** дахь баянбүрдэд аваачна ... тэндээс **12 тагнуулыг** өвөг дээдэст нь Бурханаас амласан Канаан нутгийг тандуулахаар илгээнэ. **Олонхийн дүгнэлт** ард олныг айлгаж, харин **цөөнхийн дүгнэлт (Иошуа, Калев нар)** Бурханы хүслээр бид газар нутгийг эзлэн авъя гэсэн авч олон нийт олонхийн дүгнэлтийг дагав. Ийнхүү Бурханы хүсэлд дуулгаваргүй хандсан Израилчууд Канаанд орох нүүдэл **40 ЖИЛ ЦӨЛД**

Өрнөх цэг

ИОСЕФ

Боолчлол

430 жил

МОСЕ

Египетээс гарсан нь

Синай

Ё-И-Ё

Кадеш Барнеа

40 жил

5 Айлдвар



ИОШУА

Иерихо / Аи

Газар хувиарлалт

АНАРХИ

Шүүгчид

350 жил

ХААНЧЛАЛ

С - Д - С

-- Хуваагдал --

Хойд Өмнөд

Израиль Иуда

10 2

Эш үзүүлэгчид

И-20 Р-20

200 350

Ассир Вавилон

Библийн Файл

#5

ИОШУА

Библийн Файл

#6

АНАРХИ

Библийн Файл

#7

ХААНЧЛАЛ

тэнүүчлэх зам руу эргэв. Цөлд 20 болон түүнээс дээш насныхан дуулгаваргүйгээсээ болж бүгд үхэв. Амлагдсан Газрын талаар **МОСЭ** шинэ үеийнхэнд тодорхой зааж, нөхцөл дурьдаагүй **ГАЗРЫН ГЭРЭЭГ (ДЭД ХУУЛЬ)** Бурханаас авав. **МОСЕ** Небо уулын бэлд шинэ үеийнхэнд хандан **5 айлдвараа** айлдсан бөгөөд тэр өөрөө Амлагдсан газар руу орж чадаагүй юм.

МОСЕгийн халааг авсан **ИОШУА** шинэ үеийнхэнийг дагуулан **Газар нутгаа** эзлэн авахаар 7 жилийн дайныг эхлүүлнэ. Израилчууд авах ёстойгоосоо хагасыг авсан ба түүнийгээ 12 овогт хуваан суурьшуулав. Ийнхүү нүүдлийн соёлоос суурин соёлд шилжив.

Иошуаг нас эцэслэсний дараа **АНАРХИ** нийгэм бүрэлдэж, тэр цагт **ШҮҮГЧ** нар гарч ирэв. Энэ бол үндэсний урвалт шарвалтын үе байлаа. **350 жил** тогтсон энэ нийгэм сүүлчийн шүүгч, эш үзүүлэгч **САМУЕЛ** Израилийн анхны хааныг тослох хүртэл үргэлжилсэн бөлгөө.

Нэгдсэн Израиль хаантай болсноор **ХААНЧЛАЛ** хэмээх нийгмийн харилцаанд шилжив. Нэгдсэн Израилийн хаад нь **САУЛ, ДАВИД, СОЛОМОН (С-Д-С)**. **САУЛ** сайн эхэлсэн авч муу төгсөв. Түүний оронд **ДАВИДЫГ** гаргаж ирснээр Бурханы өмнөөс амласан **АБРАХАМЫН ГЭРЭЭНИЙ**

“**ҮР ХҮҮХЭД**” өгнө гэсэн амлалт **ДАВИДЫН ГЭРЭЭ**гээр баяжигдав. **ДАВИДЫГ** хүү **СОЛОМОН** нь залгамжлав. Соломоныг нас барсны дараа Израильд **ИРГЭНИЙ ДАЙН** дэгдэж улс нь **ХОЙД (Израиль, 10 овог), ӨМНӨД (Иуда, 2 овог)** хаанчлал гэж хуваагдав. Хойд хаанчлалд **Иеробоамаар эхэлсэн 20 хаад**, Өмнөдөд **Рехобоамаар эхэлсэн 20 хаад** тус тус гарч ирэв. Хуваагдлаас хойш **200 жилийн** дараа Хойд хаанчлал **Ассирт** олзлогдож тархан бутрав. Хуваагдлаас хойш **350 жилийн дараа** Өмнөд хаанчлал **Вавилонд** олзлогдон, **Иерусалим** болоод **Сүм** нь нураагдав. Ийм цаг үед Иеремиагаар дамжуулан **ШИНЭ ГЭРЭЭГ** Эзэн өгөв.

Библийн Файл
#8
КОЛОНЧЛОЛ

70 жилийн дараа Вавилоны шинэ хаан Иудейчүүдийг **Иерусалимд** буцаж, **Сүмээ** сэргээн байгуулахыг зөвшөөрөв. **100 жилийн** хугацаанд **3 нүүдлээр 50,000 Иудейчүүд** эргэж ирсэн ба тэднийг **ЗЕРУББАБЕЛ, ЕЗРА, НЕХЕМИА (З-Е-Н)** гэсэн гурван удирдагч удирдагч байлаа. Ийнхүү **Хуучин Гэрээ** төгсөв.

Библийн Файл
#9
ЧИМЭЭГҮЙ ҮЕ

Библийн **ЧИМЭЭГҮЙ ҮЕ** гэж энэхүү **400 жилийг** нэрлэдэг. Энэ үед **АГУУ АЛЕКСАНДР ГРЕК** хэл, соёлыг түгээнэ. Дараа нь **РОМ** засаглалын дэвшингүй **СИСТЕМ**ийг бий болгоно.

Өрнөх цэг

ДГ

ШГ

КОЛОНЧЛОЛ
70 жил
3 Нүүдэл
100 жил / 50,000
З - Е - Н

ЧИМЭЭГҮЙ ҮЕ
Грекийн Александр
Ромын систем

ЕСҮС

Амьдрал

Загалмай

Чуулган

Сайн мэдээ

Үйлс

Захидлууд

Илчлэлт

Матай номын эхний бүлэгт **ЕСҮС**ийг танилцуулна. Шинэ Гэрээнээс **ЕСҮСИЙН АМЬДРАЛ, ЗАГАЛМАЙ -** Түүний үхэл, оршуулга, амилалт болон **ЧУУЛГАНЫ** түүхэн хөгжлийг харна. Энэ бүхнийг багтаасан **Сайн мэдээний номууд, Үйлс, Захидлуудыг** Шинэ Гэрээ бидэнд бий. **АБРАХАМЫН ГЭРЭЭГЭЭР** нөхцөл дурьдалгүй амласан авралын төлөвлөгөө **Илчлэлт** номд гарна. **Давидын удам, ЕСҮС ХРИСТИЙН** жинхэнэ дүр төрх ирээдүйд ямар байхыг, ирээдүйн тухай зурвас зураглалыг энэхүү номоос харна. Ирээдүйд дэлхий ертөнц юу болох Бурханы **ерөөл** бүх ард түмэнд хэрхэн түгэхийг ч мөн унших болно.

БҮТЭЭЛ

АБРАХАМ

ИОСЕФ

МОСЕ

ИОШУА

АНАРХИ

ХААНЧЛАЛ

КОЛОНЧЛОЛ

ЧИМЭЭГҮЙ ҮЕ

ЕСҮС

ЭЦЭСТ НЬ ДҮГНЭХЭД ...

Бүтэн Библийг цэгцтэйгээр ойлгомжтой ойлгох файлын системийг тархиндаа бий болголоо.

Библийн Файл хоорондоо холбоо сүлбээгүй ч юм шиг олон хэсгүүдийг уялдаатай цэгцтэй болгож өглөө. Энэ нь Христэд итгэгч хүний хувьд Эзэний Үгийг шамдан суралцах зөв суурийг танд тавьж өгч байгаа юм.

Бид анх үсэг, тоо нийлсэн 4 тэмдэгтийг нэрлэн цээжилж байсныг санаж байна уу?

Б 7 Ч Е

Энэ нь задраад 10 чухал үгийг бүтээсэн ...

**БҮТЭЭЛ
АБРАХАМ
ИОСЕФ
МОСЕ
ИОШУА
АНАРХИ
ХААНЧЛАЛ
КОЛОНЧЛОЛ
ЧИМЭЭГҮЙ ҮЕ
ЕСҮС**

... үүнийгээ бид оюун ухаандаа **Библийн файл** (хавтас) нээж тус бүрт нь нэрлээд түүнийгээ дэлгэрүүлэн үзсэн. Үүнийг бид **“Библийн үндсэн он тооллын хураангуй”** болгон судалсан.

Бүтэн хураангуйг номын 59-р талаас харна уу. Бурханы авралын төлөвлөгөөг Эхлэл-Илчлэлт хүртэл, Хуучин-Шинэ Гэрээ хүртэл харлаа. Абрахамаас энэ бүхэн эхэлж Есүс Христ хүртэл чиглэж байгааг бид мэдлээ. Эзэн бидэнд ийнхүү хэлсэн юм:

“Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Миний үгийг сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс өнгөрч амь уруу шилжив” (Иохан 5:24)

Библийг дотроо цэгцтэй ойлгосон байхад

Өрнөх цэг




*Оюун ухаандаа бүтээх
Файл хадгалах шүүгээ.
(Библийн Файл)*

Энэ дөрвөн тэмдэгтээс ...

Б 7 Ч Е

... тэгээд задрахад ...

**БҮТЭЭЛ
АБРАХАМ
ИОСЕФ
МОСЕ
ИОШУА
АНАРХИ
ХААНЧЛАЛ
КОЛОНЧЛОЛ
ЧИМЭЭГҮЙ ҮЕ
ЕСҮС**



Өрнөх цэг

*“Чи өөрийгөө ичих
явдалгүй ажилчин,
үнэний үгийг зөв заагч
гээж Бурханд сайшаалган
харуулахыг хичээгтүн.”*
2 Тимот 2:15

*Жинхэнэ итгэл Библийн
баримт дээр л суурилсан
байх ёстой!*

Ариун Сүнс таны амьдралд шууд үгээ хэлэх болтугай!

Библи бол Бурхан Эцгээс хүүхдүүдээ хандсан “Хайрын захиа” гэдэг. Ямар ч нөхцөл байдалд зөв амьдрахын тулд Библийг бид мэддэг, бас түүгээрээ амьдардаг байх ёстой (2 Тимот 2:15). Тиймд утгыг нь олж суралцахад тань цэгцтэй ойлголт эхнээсээ байх нь үнэхээр чухал.

Библийн Файл таны амьдралд *Библийг цэгцтэйгээр бодож чаддаг төвшинд* хүргээсэй хэмээн бид залбирч байна. Бидний Христитгэл бол түүхэн, баримт дээр суурилсан, эмх цэгцтэй Бурханы Үгэнд суурилсан итгэл бишрэл юм.

Майлс Станфорд нэгэн удаа ийнхүү хэлсэн байна: **“Бидний итгэл баримт дээр тулгуурлахаас нааш тэр нь ердөө л таамаглал, мухар сүсэг болон өөртөө итгэх итгэл болж хувирна”**.

БИБЛИ ... ҮНДСЭНДЭЭ сургалт Библийг цэгцтэй мэдээд, түүнийхээ дагуу цэгцтэй амьдрах мөнхийн ерөөлийг танд авчрах суваг болоосой хэмээн залбирч байна!

БИБЛИЙН ФАЙЛ “ОН ТООЛЛЫН ХУРААНГУЙ”

Б

БҮТЭЭЛ Абрахамаас өмнөх
бүх цаг үе

Эхний эр, эм

Эхний гэм

Эхний сайн мэдээ

Эхний гэр бүл

Эхний аллага

Үер / Солонго

Цамхаг

АБРАХАМ МЭӨ 2000 он

Дуудлага

Г - Ү - Е

И - И

И - Е

12

АГ

ИОСЕФ

Боолчлол

430 жил

МОСЕ МЭӨ 1500 он

Египетээс гарсан нь

Синай

Ё-И-Ё

Кадеш Барнеа

40 жил

5 Айлдвар

ДХ

ИОШУА

Иерихо / Аи

Газар хувиарлалт

4 ХҮН

3 ИЙГЭН

АНАРХИ

Шүүгчид

350 жил

ХААНЧЛАЛ МЭӨ 1000 он

С - Д - С

-- Хуваагдал --

Хойд Өмнөд

Израиль Иуда

10 2

Эш үзүүлэгчид

И-20 Р-20

200 350

Ассир Вавилон

ДГ

ШГ

КОЛОНЧЛОЛ

70 жил

3 Нүүдэл

100 жил / 50,000

3 - Е - Н

ЧИМЭЭГҮЙ ҮЕ МЭӨ 500 он

Грекийн Александр

Ромын систем

Ч

ЕСҮС

Амьдрал

Загалмай

Чуулган

Сайн мэдээ

Үйлс

Захидлууд

Илчлэлт

Е

